МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

ЭРХ МЭДЭЛ, АЛБАН ТУШААЛАА УРВУУЛАН АШИГЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ БА ХАРИУЦЛАГЫН ТОГТОЛЦОО

Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Судалгааны код: СТ-25/246
Хугацаа: 2025.10.23

Захиалагч: УИХ-ын гишүүн Ц.Мөнхбат

Хянасан: Эрдэмтэн нарийн бичгийн дарга Д.Онолт
Судалгааны хэлтсийн дарга Г.Гэсэр

Судалгаа удирдсан: Судалгааны хэлтсийн зөвлөх Г.Билгээ

Судлаач: Ц.Ариунаа

Улаанбаатар хот, 2025

Агуулгын товьёг

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ 2

УДИРТГАЛ 3

Нэг. ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ДАХЬ ЭРХ МЭДЭЛ, АЛБАН ТУШААЛАА УРВУУЛАН АШИГЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭ БА НЭР ТОМЬЁО 4

1.1.Гэмт хэргийн эрх зүйн хүрээ 4

1.2.Хуулийн нэр томьёоны хэрэглээ 7

1.3.Нэгдүгээр бүлгийн үр дүн 11

Хоёр. ЭРХ МЭДЭЛ, АЛБАН ТУШААЛАА УРВУУЛАН АШИГЛАХ НОГДУУЛАХ ЭРҮҮГИЙН БА ЭРҮҮГИЙН БУС ХАРИУЦЛАГА 13

2.1.Эрүүгийн хариуцлага хүлээлгэх 13

2.2.Эрүүгийн бус хариуцлага хүлээлгэх 15

2.3.Хоёрдугаар бүлгийн үр дүн 17

Гурав. ХУУЛЬ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД 19

3.1.Мөрдөн шалгах ажиллагаа ба авлигатай тэмцэх тусгай байгууллага 19

3.2.Прокурорын хяналт ба удирдамжийн цар хүрээ 20

3.3.Гуравдугаар бүлгийн үр дүн 22

СУДАЛГААНЫ ҮР ДҮН 24

НОМ ЗҮЙ 26

ХАВСРАЛТУУД 27

Хавсралт 1. Австрали Холбооны Улсын 1995 оны Эрүүгийн хуулиас 27

Хавсралт 2. Бүгд Найрамдах Казахстан Улсын Эрүүгийн хуулиас 28

Хавсралт 3. Бүгд Найрамдах Солонгос Улсын Эрүүгийн хуулиас 29

Хавсралт 4. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Эрүүгийн хуулиас 29

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашиглах гэмт хэрэгт оноох хариуцлагын харьцуулалт 13

Хүснэгт 2. Төрийн (нийтийн) албан хаагчийн эрүүгийн бус хариуцлагын харьцуулалт 18

Хүснэгт 3. Хууль хэрэгжүүлэгч байгууллагуудын харьцуулалт 23

УДИРТГАЛ

“Эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашиглах гэмт хэргийн эрүүгийн хуулийн зохицуулалт ба хариуцлагын тогтолцоо” сэдэвт харьцуулсан судалгааг Улсын Их Хурлын Тамгын газрын дэргэдэх Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнд гүйцэтгэв.

Судалгааны зорилго: Төрийн (нийтийн) албан тушаалтны эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашиглах үйлдэл нь төрийн үйл ажиллагаанд итгэлцлийг алдагдуулж, шударга ёсны зарчмыг зөрчин, авлигын шинжтэй зөрчлийн нэг хэлбэр болон илэрдэг. Иймд энэхүү судалгаагаар сонгогдсон улс орнуудын эрх зүйн зохицуулалтад эрх мэдлээ урвуулан ашиглах гэмт хэргийн тодорхойлолт, хариуцлагын тогтолцоо, ял шийтгэлийн бодлогын онцлогийг харьцуулан шинжлэх, мөн хэрэгжилтийн практикт ямар арга үр нөлөөтэй болохыг тодорхойлох зорилготой.

Судалгааны хамрах хүрээ: Судалгаанд хамруулах улсуудыг эрх зүйн бүлийн төлөөлөл, хууль хэрэгжилт ба засаглалын түвшин, авлигын индексийн ялгаатай байдал зэрэг үзүүлэлтэд тулгуурлан сонгосон. Энэ хүрээнд хөгжлийн түвшин, эрх зүйн тогтолцооны онцлогийг харьцуулан судлахад оновчтой гэж үзэж, Австралийн Холбооны Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын эрүүгийн хууль дахь эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашиглах гэмт хэрэгт холбогдох зохицуулалт болон мөрдөн шалгах, яллах, хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоог хамруулсан болно.

Судалгааны бүтэц:

Нэгдүгээр бүлэгт, эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашиглах гэмт хэргийн эрх зүйн хүрээ, нэр томьёоны хэрэглээ, гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг авч үзсэн.

Хоёрдугаар бүлэгт, эрүүгийн болон эрүүгийн бус хариуцлагын тогтолцоо, ял шийтгэлийн бодлого, сахилгын болон ёс зүйн хариуцлагын зохицуулалтыг харьцуулан дүгнэсэн.

Гуравдугаар бүлэгт, уг гэмт хэргийг мөрдөн шалгах, яллах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцдог хяналтын байгууллагуудын уялдаа холбоог судалсан.

Судалгааны арга зүй: Судалгаанд сонгогдсон улс орнуудын Эрүүгийн хууль болон холбогдох хууль тогтоомжийг харьцуулан шинжилж, эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашиглах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтын онцлогийг тодорхойлсон. Үүний зэрэгцээ хууль хэрэгжүүлэгч байгууллагуудын албан ёсны цахим эх сурвалж, олон улсын байгууллагын тайлан болон эрдэм шинжилгээний бүтээлүүдийг ашиглаж шинжилгээ хийсэн. Судалгааны зорилгод нийцүүлэн эрх зүйн харьцуулсан арга болон хүснэгтэн харьцуулалтыг хослуулан хэрэглэж, улмаар эрх зүйн заалтын уялдаа, хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэхийг зорьсон.

Түлхүүр үгс: эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашиглах гэмт хэрэг, авлигын гэмт хэрэг, нийтийн албан тушаалтан, нийтийн ашиг сонирхол, эрүүгийн хариуцлага, эрүүгийн бус хариуцлага, мөрдөн шалгах ажиллагаа, прокурорын хяналт, хэрэгжилтийн тогтолцоо

Key words: abuse of power and official misconduct, corruption offence, public official, public interest, criminal liability, non-criminal responsibility, investigation process, prosecutorial oversight, enforcement system, integrity in public service

Нэг. ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ДАХЬ ЭРХ МЭДЭЛ, АЛБАН ТУШААЛАА УРВУУЛАН АШИГЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭ БА НЭР ТОМЬЁО

1.1.Гэмт хэргийн эрх зүйн хүрээ

Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын 2003 оны Авлигын эсрэг конвенцийн[1] 19 дүгээр зүйлд төрийн албан тушаалтан эрх мэдэл, албан тушаалаа хууль бус зорилгоор ашиглаж, өөртөө, эсхүл бусдад ашиг хүртээх, эсхүл бусдад хохирол учруулсан тохиолдолд түүнийг “эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашиглах” гэмт хэрэгт тооцох тухай заасан. Конвенц нь гишүүн улсуудыг уг төрлийн гэмт хэргийг хууль тогтоомждоо тусгах асуудлыг авч үзэхийг уриалдаг (United Nations, 2003).

Энэ төрлийн гэмт хэрэг нь авлигын үндсэн хэлбэрийн нэг бөгөөд төрийн албан тушаалтны үүргээ зөрчих хамгийн ноцтой хэргийн нэг юм.

1.1.1.Австралийн Холбооны Улс

Австрали Улсын 1995 оны *Эрүүгийн хуулийн*[2] “Төрийн зөв зохистой удирдлага” 7 дугаар бүлэгт[3], түүн доторх “Авлигын болон холбогдох гэмт хэрэг” 7.6 дугаар хэсэгт[4] нийтийн албан тушаалтай холбоотой хэд хэдэн гэмт хэргийг хуульчилсан байдаг. Эдгээрийн дотор “нийтийн албан тушаалаа урвуулан ашиглах” (Abuse of public office) гэмт хэргийг хуулийн 142.2 дугаар зүйлд зохицуулжээ.

Уг зүйлийн дагуу Холбооны нийтийн албан тушаалтан өөрийн эрх мэдэл, үйл ажиллагаа, эсхүл мэдээллийг өөртөө, эсхүл бусдад хууль бус ашиг хүртээх, эсхүл бусдад хууль бус хохирол учруулахыг гэмт хэрэгт тооцно (§142.2).

Эрүүгийн хуулийн 142.2 дугаар зүйлд нийтлэг бүрэлдэхүүнийг тусгасан боловч дараах ***онцлогтой***:

- субъектын өргөн хүрээг хамруулсан **-**
    - зөвхөн сонгуульт албан тушаалтан биш, “Холбооны нийтийн албан тушаалтан” (Commonwealth public official) гэж холбооны төрийн алба хашиж буй өргөн хүрээний албан тушаалтныг хамруулдаг (§142.2);
- “ашиг” ба “хохирол”-ын ойлголтыг мөн өргөнөөр тодорхойлсон (§130.1) -
    - “ашиг” (gain) нь зөвхөн мөнгө, эд хөрөнгө бус, үйлчилгээ авах зэрэг аливаа давуу байдалтай үлдэх хүртэл хамарна;
    - “хохирол” (loss) нь мөнгөн хохирол төдийгүй авах гэж байсан зүйлийг авч чадаагүй боломжийг;
- “шударга бус” (dishonest) гэдэг нь нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн шударга ёсны нийтлэг стандартын дагуу шударга бусад тооцогдох аливаа үйлдэл, мөн тухайн этгээд өөрөө уг үйлдэл нь хууль бус болохыг ухамсарлаж, мэдсээр байж үйлдсэн тохиолдлыг хамарна (§130.3).

Эрүүгийн хуулийн 142.2 дугаар зүйлд тусгайлан “хүндрүүлэх нөхцөл” заагаагүй боловч заалтын үйлчлэх хүрээг өргөтгөн ***албан тушаалаасаа чөлөөлөгдсөний***

[1] Монгол: Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийг соёрхон батлах тухай (2005). Хандах: https://legalinfo.mn/mn/detail/10269/2/2064
[2] Австрали: Criminal Code Act (1995). Хандах: https://www.legislation.gov.au/C2004A04868/2018-12-29/text
[3] Chapter 7 - The proper administration of Government.
[4] Part 7.6 - Bribery and related offences.

дараах хэрэглээг зохицуулсан байна. Тодруулбал, аливаа этгээд нь тодорхой албан тушаал дахь Холбооны нийтийн албан тушаалтан чөлөөлөгдсөн ч, албан тушаалтны хувиар ажиллаж байхдаа олж авсан мэдээллээ ашиглаж, хэн нэгэнд зориуд хүрэхээр үйлдэл хийсэн бол гэмт хэрэгт тооцно (§142.2(2)):

- өөртөө, эсхүл бусдад хууль бус байдлаар ашиг хүртэх;
- бусдад хууль бусаар хохирол учруулах.

Энд "чөлөөлөгдсөн" гэсэн нь өргөн утгатай (§142.2(3):

- тухайн этгээд нь өөр нэгэн албан тушаалд Холбооны нийтийн албан тушаалтан хэвээр үлдсэн эсэхээс үл хамаарна;
- чөлөөлөгдсөн энэ заалт хүчин төгөлдөр болохоос өмнө, хэрэгжих үед, эсхүл хойно гарсан эсэхээс үл хамаарна.

(Австрали Улсын 1995 оны Эрүүгийн хуулийн 142.2 дугаар зүйлийг Хавсралт 1-ээс үзнэ үү.)

1.1.2.Бүгд Найрамдах Казахстан Улс

Казахстан Улсын 2014 оны *Эрүүгийн хуулийн*[5] "Төрийн алба болон төрийн удирдлагын ашиг сонирхлын эсрэг чиглэсэн авлигын болон бусад эрүүгийн гэмт хэрэг" 15 дугаар бүлэгт[6] (§361-371) төрийн албан тушаалтнуудын ашиг сонирхлын зөрчил, авлига, хахууль, эрх мэдлээ хэтрүүлэх, албаны журам зөрчих, хуурамч материал ашиглах зэрэг төрийн алба, үйл ажиллагаанд ноцтой нөлөөлөх гэмт хэргүүдийг зохицуулдаг.

Эдгээрээс "Албан тушаалын бүрэн эрхийг урвуулан ашиглах" (Злоупотребление должностными полномочиями) гэмт хэргийг хуулийн 361 дүгээр зүйлд зохицуулсан байна. Энэ зүйл нь "албан тушаалын бүрэн эрхийг урвуулан ашиглах" гэмт хэрэг нь зөвхөн эрх бүхий этгээдээр үйлдэгдэх боломжтой, хууль бус ашиг болон хор уршгийн зорилготой гэсэн үндсэн шинжийг хадгалж байна. Тухайлбал:

- гэмт хэргийн субъект нь төрийн үүрэг гүйцэтгэх эрх бүхий этгээд, түүнтэй адилтгах этгээд, эсхүл албан тушаалтан байх бөгөөд эрх мэдлийн тодорхой хүрээтэй этгээдээр үйлдэгдэх;
- үйлдлийн мөн чанар нь албан тушаалын бүрэн эрхийг албаны ашиг сонирхолд харш байдлаар ашиглах бөгөөд ингэснээр:
  - өөртөө, эсхүл бусдад ашиг, давуу байдал бий болгох;
  - бусдад, байгууллагад хохирол учруулах зорилготой байна;
- хохирлын шинж нь иргэн, байгууллагын хууль ёсны эрх, ашиг сонирхолд, эсхүл нийгэм, төрийн хуульд хамгаалагдсан ашиг сонирхолд үлэмж хохирол учирсан байхыг шаардана.

Харин ***онцлог*** нь ял шийтгэлийн олон төрөл, тусгай субъектүүдээс хамаарч ял шийтгэлийг ***хүндрүүлэх нөхцөлийг*** нарийвчилж зохицуулсан байна. Үүнд:

- дараах субъектууд үйлдсэн бол ял шийтгэлийг хүндрүүлнэ:
  - хууль сахиулах байгууллагын ажилтан (§361.2-1);

[5] Казахстан: Уголовный кодекс (2014). Хандах: https://online.zakon.kz/Document/?doc_id=31575252&pos=5;-109#pos=5;-109

[6] Глава 15. Коррупционные и иные уголовные правонарушения против интересов государственной службы и государственного управления.

- хариуцлагатай төрийн албан тушаалтан (§361.3);
- хууль сахиулах байгууллагын хариуцлагатай албан тушаалтан (§361.4);
- шүүгч (§361.4);

- дараах нөхцөлтэйгээр үйлдэгдсэн бол ял шийтгэлийг хүндрүүлнэ (§361.4):
  - гэмт хэргийн бүлгийн ашиг сонирхлын төлөө;
  - хуульд заасан үүрэг гүйцэтгэх явцад олж авсан мэдээллийг ашигласан;
  - хүнд хор уршиг учруулсан.

(Казахстан Улсын Эрүүгийн хуулийн 361 дүгээр зүйлийг Хавсралт 2-оос үзнэ үү.)

1.1.3.Бүгд Найрамдах Солонгос Улс

Солонгос Улсын *Эрүүгийн хуулийн*[7] VII бүлэг болох "Нийтийн албан тушаалтны үүрэгтэй холбоотой гэмт хэрэг"[8] нь албан үүргийн зөрчилтэй холбоотой хэд хэдэн гэмт хэргийг хуульчилсан байдаг. Тэдгээрийн дотор "эрх мэдлээ урвуулан ашиглах" (Abuse of Authority) үйлдлийг 123 дугаар зүйлийн дагуу гэмт хэрэгт тооцдог.

Уг зүйлд нийтийн албан тушаалтан өөрт олгогдсон албан тушаалын эрх мэдлээ буруугаар ашиглаж: (а) бусдаар хийх ёсгүй үйлдлийг хийлгэсэн, эсхүл (б) тухайн хүнийг эдлэх эрхээ хэрэгжүүлэхээс саатуулсан бол гэмт хэргийн бүрэлдэхүүн бүрдэхийг тогтоосон.

Тус гэмт хэрэгт хүндрүүлэх нөхцөлийг 123 дугаар зүйлд шууд тусгаагүй. Нийтийн албан үүргийн хүрээнд үйлдэгдсэн гэмт хэрэгт ял шийтгэлийг ***хүндрүүлэх нөхцөлийг*** Эрүүгийн хуулийн 135 дугаар зүйлд "Албан үүргийн хүрээнд үйлдсэн гэмт хэрэгт оноох ялыг хүндрүүлэх"-ийг тусгайлан зохицуулсан. Энэ зүйлд гэмт хэрэг нь хүнд үр дагавартай байж, бүлэглэлийн ашиг сонирхолд үйлчилсэн, эсхүл онцгой нөхцөлд үйлдэгдсэн тохиолдолд ял шийтгэлийг хүндрүүлэн оногдуулах эрх зүйн үндсийг тогтоосон байдаг.

(Солонгос Улсын Эрүүгийн хуулийн 123 дугаар зүйлийг Хавсралт 3-аас үзнэ үү.)

1.1.4.Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Герман Улсын *Эрүүгийн хуулийн*[9] 30 дугаар бүлэгт[10] (албан тушаалтай холбоотой гэмт хэрэг) нийтийн албан тушаалтны үйлдэгддэг гэмт хэргүүдийг системтэйгээр хуульчилсан байдаг (§331-358). Гэвч тус зүйлд эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашиглах гэмт хэргийг нэг дор зохицуулаагүй байна. Харин нийтийн албан тушаалтны эрх мэдэл, чиг үүргийг хууль бус зорилгоор ашиглах ялгаатай нөхцлийг дараах байдлаар зохицуулсан нь онцлог байна. Үүнд:

- шүүхийн шударга ёсыг гажуудуулах (§339) - энэ зүйл нь шүүгч, зууч шүүгч зэрэг этгээд хуулийг зориуд гажуудуулсан үйлдлийг хамардаг;
- гэм буруугүй этгээдийг яллах (§344) болон түүнд шийтгэл гүйцэтгэх (§345) - эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд 344 дүгээр зүйл нь яллах ажиллагааны шатанд гэм буруугүй этгээдийг яллахыг, 345 дугаар зүйл нь шийтгэлийг гүйцэтгэх шатанд хуульд нийцээгүй шийтгэл хэрэгжүүлэхийг тус тус гэмт хэрэгт тооцдог;

[7] Солонгос: Criminal Act (2013). Хандах: https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=28627&lang=ENG
[8] Chapter VII - Crimes Concerning the Duties of Public Officials.
[9] Герман: Strafgesetzbuch, StGB (1998). Хандах: https://www.gesetze-im-internet.de/englisch_stgb/
[10] Division 30 - Offences committed in public office.

- албан бичиг баримтыг хуурамчаар үйлдэх (§348) - энэ зүйл нь албан тушаалтан эрх хэмжээнийхээ хүрээнд худал баталгаажуулалт хийсэн тохиолдлыг хамардаг;
- илүү төлбөр, хөлс нэхэмжлэх (§352) болон илүү татвар, төлбөр хураах, хууль бусаар хөнгөлөлт үзүүлэх (§353) - энэ зохицуулалт нь төлбөр, татвар, хураамжийг хууль бусаар нэмэгдүүлэх, олголтыг бууруулах зэрэг санхүүгийн урвуулалтыг тусгайлан зохицуулдаг.

Дээрх зохицуулалтад хүндрүүлэх нөхцөлийг тусгаагүй. Үүний оронд (а) үндсэн ялын хүрээг өндөр тогтоох, (б) гэмт хэрэг үйлдэхийг завдах үйлдлийг шийтгэх (зарим зүйл), (в) нийтэд нь "Нэмэлт эрх зүйн үр дагавар"-ыг (§358 - Incidental legal consequences) хэрэгжүүлэх зэргийг зохицуулсан байна. Хуулийн 358 дугаар зүйлд зааснаар, хэрэв зургаан сараас дээш хугацаагаар хорих ял оногдвол шүүх нь тухайн этгээдийн нийтийн албан тушаал эрхлэх эрхийг хасна.

Эрүүгийн хуульд ***хариуцлага тооцох дараах нөхцөлийг*** зохицуулжээ:

- оролдлогод (attempt) шийтгэл оногдуулах заалт -
  - гэм буруугүй этгээдийг яллах (§344);
  - албан бичиг баримтыг хуурамчаар үйлдэх (§348);
  - илүү төлбөр, хөлс нэхэмжлэх (§352);
- хөнгөн тохиолдол (in less serious cases) зохицуулсан заалт -
  - гэм буруугүй этгээдийг яллах (§344);
  - гэм буруугүй этгээдэд шийтгэх шийдвэрийг хууль бусаар гүйцэтгэх (§345);
- болгоомжгүйгээр үйлдсэн (reckless) хэлбэрийг тусгайлан зохицуулсан заалт -
  - гэм буруугүй этгээдэд шийтгэх шийдвэрийг хууль бусаар гүйцэтгэх (§345(2)).

Эрүүгийн хуулийн "Ялын тогтоолын ерөнхий зарчим" 46 дугаар зүйлийн дагуу шүүх хэрэг, этгээдийн нийт байдлыг (үйлдлийн арга хэлбэр, эрх мэдлийн түвшин, хор уршгийн хэмжээ, зохион байгуулалт гэх мэт) цогцоор нь үнэлж ял тохируулдаг. Иймд тусгай "хүндрүүлэх нөхцөл"-гүй зүйлд ч бодит нөхцөл байдалд чангарсан ял оногдуулах боломж нээлттэй.

(Герман Улсын Эрүүгийн хуулийн 339, 344, 345, 348, 352, 353 дугаар зүйлийг Хавсралт 4-өөс үзнэ үү.)

1.2.Хуулийн нэр томьёоны хэрэглээ

НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийн[11] 19 дүгээр зүйлд уг гэмт хэргийг "чиг үүргээ урвуулан ашиглах" (abuse of functions), "албан тушаалаа урвуулан ашиглах" (abuse of office) зэрэг нэр томьёогоор илэрхийлсэн байдаг (United Nations, 2003).

Тус конвенцийн 2 дугаар зүйлд уг гэмт хэрэгт хамаарах нэр томьёонуудыг тодорхойлсон байдаг. *(Нэр томьёоны тодорхойлолтыг Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийг соёрхон батлах тухай хуулийн хавсралтаас үзнэ үү.)*

[11] Монгол: Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийг соёрхон батлах тухай (2005). Хандах: https://legalinfo.mn/mn/detail/10269/2/2064

1.2.1.Австралийн Холбооны Улс

1995 оны Эрүүгийн хуульд “нийтийн албан тушаалтан” болон “Холбооны нийтийн албан тушаалтан” гэсэн хоёр ойлголтыг ялган тодорхойлсон байна (2 дугаар ботийн “Толь бичиг” хэсэг):

- “нийтийн албан тушаалтан” (public official) - Холбоо, муж, нутаг дэвсгэр зэрэг бүх түвшний төрийн байгууллагын албан тушаалтан (төрийн байгууллагын албан тушаалтан ба ажилтан, гэрээгээр төрийн ажил гүйцэтгэдэг хувь хүн, цэргийн болон цагдаагийн алба хаагчид, мөн гүйцэтгэх, шүүх болон хууль тогтоох байгууллагын гишүүд гэх мэт)-ууд хамарсан өргөн хүрээний ойлголт бол;
- “Холбооны нийтийн албан тушаалтан” (Commonwealth public official) - Холбооны түвшинд эрх мэдэл хэрэгжүүлэгч, эсхүл Холбооны хуулиар албан тушаал, чиг үүрэг олгогдсон этгээд (Ерөнхий амбан захирагч (Governor-General), сайд, Парламентын гишүүн, Парламентын нарийн бичгийн дарга, Холбооны шүүхийн албан тушаалтан, Австралийн нийтийн албан хаагч, Австралийн Батлан хамгаалах хүчний гишүүн, Холбооны цагдаагийн энгийн ба тусгай гишүүд, Холбооны эрх бүхий байгууллагын албан тушаалтан ба ажилтан, Холбооны гэрээний хүрээнд үйлчилгээ үзүүлэгч болон түүний ажилтан, түүнчлэн Холбооны хуулиар эрх мэдэл, чиг үүрэг этгээд гэх мэт)-үүд хамарна.

Мөн албан тушаалаа урвуулан ашиглах гэмт хэрэгт хамаарах нэр томьёог Эрүүгийн хуульд дараах байдлаар тодорхойлсон байна:

- “үүрэг” (duty) гэдэгт албан тушаалтан болохын хувьд түүнд албан ёсоор олгогдсон эрх (authority), үүрэг (duty), чиг үүрэг (function), эсхүл эрх мэдэл (power)-ийг ойлгоно., эсхүл, хэн нэгэн этгээд өөрийгөө холбооны төрийн албан тушаалтан мэтээр үзүүлж, ийм эрх, үүрэг, чиг үүрэг, эсхүл эрх мэдэлтэй гэж үзүүлсэн нь мөн тооцогдоно (§130.1);
- “өмч” (property) гэдэгт үл хөдлөх хөрөнгө, хөдлөх хөрөнгө, мөнгө, эрхийн шаардлага (thing in action) болон бусад биет бус өмч, цахилгаан (electricity), мөн зэрлэг амьтныг хамаарна (§130.1);
- “үйлчилгээ” (services) гэдэгт ямар ч төрлийн эрх, ашиг, давуу байдал, боломж, байгууламж (facilities)-ийг хамруулна (үүнд үл хөдлөх, хөдлөх хөрөнгөтэй холбоотой эрх, эрхийн ашиг сонирхлыг багтаана). Гэвч үүнд бараа нийлүүлэхтэй адилтгах эрх, ашгийг хамруулахгүй
- “давуу байдал” (benefit) нь аливаа давуу байдлыг багтаах бөгөөд зөвхөн эд хөрөнгөөр хязгаарлагдахгүй (§140.1).

Иймхүү Эрүүгийн хуульд нэр томьёоны хамрах хүрээг өргөнөөр тодорхойлсон байна. Тухайлбал, “үүрэг” нь зөвхөн албан ёсоор томилогдсон бус, харин “үзүүлсэн” статуст ч үйлчилдэг бол “хохирол” нь авч чадаагүй боломжийг ч хамруулж байна.

1.2.2.Бүгд Найрамдах Казахстан Улс

Эрүүгийн хуулийн 3 дугаар зүйлд “албан тушаалын бүрэн эрхийг урвуулан ашиглах” гэмт хэргийн субъектүүдийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- “албан тушаалтан” (должностное лицо) гэж төрийн байгууллага, орон нутгийн өөрөө удирдах байгууллага, мөн Зэвсэгт хүчин, бусад цэрэг, цэргийн нэгтгэлүүдэд төрийн эрх мэдлийг төлөөлөх чиг үүрэг гүйцэтгэх, эсхүл зохион

байгуулалт-удирдлагын болон захиргаа-эдийн засгийн чиг үүргийг байнгын, түр хугацаагаар, эсхүл тусгай бүрэн эрхийн үндсэн дээр хэрэгжүүлдэг этгээдийг хэлнэ (§3.26);

- “хариуцлагатай төрийн албан тушаал хашиж буй этгээд” (лицо, занимающее ответственную государственную должность) гэж Үндсэн хууль болон бусад хуулиар тогтоосон, төрийн шууд үйл ажиллагааг хэрэгжүүлэх болон төрийн байгууллагын бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой албан тушаалыг эрхэлж буй этгээдийг ойлгоно. Үүнд, Парламентын төлөөлөгч, Үндсэн хуулийн шүүхийн шүүгч, шүүгч, Хүний эрхийн асуудал эрхэлсэн Омбудсмэн, мөн тус улсын төрийн албаны тухай хууль тогтоомжийн дагуу улс төрийн шинжтэй төрийн албан тушаал, эсхүл “А” ангиллын удирдах шатны төрийн захиргааны албан тушаалыг эрхэлж буй этгээд хамаарна (§3.16);
- “төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхээр эрх олгогдсон албан тушаалтантай адилтгах этгээд” (лицо, приравненное к лицам, уполномоченным на выполнение государственных функций) гэж товчхондоо орон нутгийн өөрөө удирдах байгууллагад сонгогдсон, эсхүл нэр дэвшигчээр бүртгэгдсэн иргэн, эдгээр байгууллагад улсын төсвийн хөрөнгөөр ажиллаж буй албан хаагч, төрийн болон хагас төрийн байгууллагад удирдлагын чиг үүрэг хэрэгжүүлдэг этгээд, худалдан авалт болон төсөл хэрэгжүүлэхэд шийдвэр гаргах эрх бүхий ажилтан, Үндэсний банк болон зохицуулах байгууллагын албан хаагч, төрийн үйлчилгээ үзүүлдэг, эсхүл хязгаарлагдмал мэдээлэлд хандах эрх бүхий ажилтан, мөн авто замын барилга дээр техникийн болон зохиогчийн хяналт хэрэгжүүлэгч этгээдийг хэлнэ (§3.28).

Мөн “үлэмж хохирол” (существенный вред) гэдэг нь Эрүүгийн хуулийн дагуу дараах үр дагаврыг ойлгоно (§3.14). Үүнд:

- хүний ба иргэний Үндсэн хуулиар баталгаажсан эрх, эрх чөлөө; байгууллагын эрх, хууль ёсны ашиг сонирхол; нийгэм, Төрийн хамгаалагдсан ашиг сонирхлыг зөрчих;
- мэдэгдэхүйц (их) хэмжээний хохирол учруулах;
- хохирогчийг хүндрэлтэй амьдралын нөхцөл байдалд оруулах;
- байгууллага, эсхүл төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах;
- чухал цэргийн арга хэмжээг саатуулах, эсхүл цэргийн нэгтгэл, анги, салбарын байлдааны бэлэн байдал, чадамжийг богино хугацаанд бууруулах;
- зэвсэглэсэн бүлэглэл, эсхүл зэвсэгтэй этгээдийн дайралтыг цаг тухайд нь илрүүлэх, эсхүл няцаах боломжийг алдах; хуурай зам, агаар, тэнгисийн цэргийн болон байлдааны техник хэрэгслийн дайралтыг цаг тухайд нь илрүүлж, няцааж чадахгүй байх; Бүгд Найрамдах Казахстан Улсын хилийг хүмүүс, тээврийн хэрэгслээр саадгүй, хууль бусаар нэвтрэхийг, улс дамнасан гэмт бүлэглэлийн хууль бус ачаа тээвэрлэлтийг таслан зогсоох арга хэмжээг авч чадахгүй байх; хилийн байгууламж, хилийн хамгаалалтын техникийн хэрэгсэлд хохирол учруулах үйлдэлд арга хэмжээ авахгүй хүлцэх;
- учруулсан хохирлын ноцтой шинжийг гэрчлэх бусад адил төрлийн үр дагавар.

1.2.3.Бүгд Найрамдах Солонгос Улс

Эрүүгийн хуулийн 123 дугаар зүйлд нийтийн албан тушаалтан өөрийн эрх мэдлээ урвуулан ашиглаж, иргэнээр өөрийн хийх ёсгүй үйлдлийг хийлгэх, эсхүл тухайн иргэн эрхээ хэрэглэхэд саад хийсэн тохиолдолд гэмт хэрэгт тооцохоор заасан.

Харин “нийтийн албан тушаалтан” гэсэн тодорхойлолтыг Эрүүгийн хуульд бус, харин Төрийн албаны тухай хуульд[12] тодорхойлсон байна. Төрийн албаны тухай хуулийн 2 дугаар зүйлд зааснаар “нийтийн албан тушаалтан” гэдэгт энэ хууль болон Орон нутгийн албан тушаалтны тухай хуульд[13] заасан албан тушаалтнууд, мөн Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон нийтийн болон орон нутгийн захиргааны байгууллагад ажиллаж буй албан хаагчдыг ойлгоно.

1.2.4.Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Эрүүгийн хуулийн 30 дугаар бүлгийн “Албан тушаалтай холбоотой гэмт хэрэг”-тэй холбоотой нэр томьёог хуульд дараах байдлаар тодорхойлжээ (§11.1):

- “нийтийн албаны албан тушаалтан” (public official) - нийтийн албан хаагч, шүүгч, эсхүл нийтийн эрх зүйн албан тушаалын харилцаанд байгаа этгээд, түүнчлэн байгууллага болон бусад эрх бүхий нэгжийн захиалгаар төрийн захиргааны чиг үүргийг хэрэгжүүлэхээр томилогдсон этгээдийг хэлнэ. Энэ тодорхойлолт нь төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхдээ ашиглаж буй зохион байгуулалтын хэлбэрээс үл хамаарч хэрэглэнэ (§11.2);
- “Европын албан тушаалтан” (European official) - Европын Комисс, Европын Төв банк, Европын аудитын танхим, Европын Холбоо (ЕХ)-ны шүүхийн гишүүн; болон түүний эрх зүйн үндсэн дээр байгуулагдсан байгууллагын төрийн албан хаагч, ажилтан; мөн ЕХ-ны чиг үүргийг гүйцэтгэхээр томилогдсон этгээдийг хэлнэ (§11.2a);
- “шүүгч” (judge) - мэргэжлийн шүүгч болон сайн дурын журмаар шүүхийн бүрэлдэхүүнд оролцдог шүүгчийг хамруулна (§11.3);
- “нийтийн албанд онцгой үүрэг хүлээгч” (person entrusted with special public service functions) - албан тушаалтан биш боловч (а) захиргааны байгууллага, эсхүл нийтийн захиргааны чиг үүрэг хэрэгжүүлдэг өөр байгууллагад ажиллаж буй; (б) мөн холбоо, нэгдэл, аж ахуйн нэгж зэрэг байгууллагад ажиллаж, тэдгээр нь захиргааны байгууллагын өмнөөс нийтийн захиргааны чиг үүргийг хэрэгжүүлдэг этгээд бөгөөд өөрийн ажил, үүргийг чин шударгаар биелүүлэхээ тангараглах эсхүл бичгээр албан ёсоор амалсан этгээдийг хэлнэ (§11.4).

Эдгээр гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжилгээнд хэрэглэгддэг нэр томьёог Эрүүгийн хуульд дараах байдлаар тодорхойлсон байдаг. Үүнд:

- “хууль бус үйлдэл” (unlawful act) - Эрүүгийн хуулийн гэмт хэргийн бүрэлдэхүүнд нийцсэн үйлдлийг хэлнэ (§11.5);
- ‘’хууль бус үр өгөөж’’ (consideration) - эдийн засгийн ашиг тусын аливаа хэлбэрийг хамарна. Үүнд, зөвхөн мөнгөн хэлбэрийн ашиг төдийгүй хөрөнгийн

[12] Солонгос: State Public Officials Act (2005). Хандах: https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=444&lang=ENG
[13] Солонгос: Local Public Officials Act (2024). Хандах: https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=69201&lang=ENG

шинжтэй үр өгөөж, эдийн бус материаллаг ашиг, давуу байдал зэрэг багтана (§11.9).

1.3.Нэгдүгээр бүлгийн үр дүн

Судалгаанд хамрагдсан улсуудын эрүүгийн хуулиудад НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийн зарчмыг үндэслэн төрийн (нийтийн) албан тушаалтны эрх мэдлийг хууль бус зорилгоор ашиглаж өөртөө, эсхүл бусдад ашиг хүртээх, эсхүл бусдад хохирол учруулах үйлдлийг гэмт хэрэгт тооцдог. Тэдгээрээс Герман Улсын Эрүүгийн хуульд энэхүү үйлдлийг ерөнхий зүйлээр бус, объектоор нь хэд хэдэн зүйлээр нарийвчлан зохицуулснаараа онцлог байна.

Энэ гэмт хэргийн ***субъект*** нь нийтлэгээр төрийн (нийтийн) албан тушаалтан байна. Улс бүр субъектын хамрах хүрээг өөрийн хуульд тодорхойлсон ба дараах онцлог ялгаа ажиглагдана:

- Австрали Улс “нийтийн албан тушаалтан” ангиллыг дотор нь “Холбооны нийтийн албан тушаалтан” гэж нарийвчилсан;
- Казахстан Улс субъектын гурван түвшний буюу “албан тушаалтан”, “хариуцлагатай төрийн албан тушаалтан” болон “адилтгах этгээд” гэж хуульчилсан;
- Герман Улс “нийтийн албаны албан тушаалтан”-аас гадна “Европын албан тушаалтан”, “нийтийн албанд онцгой үүрэг хүлээгч” зэрэг нэмэлт ангиллыг тусгасан;
- Солонгос Улс: “нийтийн албан тушаалтан” тодорхойлолтыг Төрийн албаны тухай хуульд тусгайлан тодорхойлсон байна.

Гэмт хэргийн ***үйлдлийн шинжийн*** хувьд, бүх тохиолдолд албан тушаалтан эрх мэдлээ хууль бус зорилгоор ашиглаж ашиг хүртээх, эсхүл хохирол учруулах нь гэмт хэрэгт тооцогдоно. Гэвч дараах онцлог ялгаатай зохицуултыг судалгаанаас харж болно:

- Австрали Улсад “шударга бус” байдлыг хоёр шалгууруар тогтоодог. Тухайн үйлдэл нь (а) нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн шударга ёсны нийтлэг стандартын дагуу шударга бус гэж тооцогдох, (б) тухайн этгээд өөрөө уг үйлдэл нь хууль бус гэдгийг мэдэж байх (§130.3);
- Казахстан Улсад гэмт хэрэгт хамааруулахын тулд учирсан хохирол нь ноцтой байхыг шаардана (§361);
- Солонгос Улсад үйлдлийн хэлбэрийг хоёр ангилдаг: иргэнээр хийх ёсгүй үйлдэл хийлгэх, эсхүл эрхээ эдлэхээс саад хийх;
- Герман Улсад нэг ерөнхий зүйлд багцлахын оронд объект, хамгаалж буй эрх ашиг тус бүрт нийцсэн олон зүйлээр (жишээлбэл, шударга ёсыг гажуудуулах, илүү төлбөр, хөлс нэхэмжлэх, албан бичгийг хуурамчаар үйлдэх, гэх мэт) тусад нь эрүүгийн хариуцлага тогтоодог.

Ашиг буюу хохирол нь зөвхөн мөнгөн хэлбэрт хязгаарлагдахгүй. Тухайлбал, Австрали Улсад “ашиг” нь үйлчилгээ, боломж хүртэл өргөн хүрээг хамарч, “хохирол” нь авч чадаагүй боломжийг хүртэл хамардаг. Казахстан Улсад “үлэмж хохирол” гэсэн босго тогтоосон бөгөөд үүнд, хүний болон иргэний үндсэн эрх зөрчих, их хэмжээний хохирол, байгууллага, эсхүл төрийн хэвийн үйл ажиллагааг доголдуулах, цэргийн бэлэн байдал буурах, хил хамгаалалт алдагдах зэрэг бодит, мэдэгдэхүйц үр дагавар хамаарна.

Солонгос ба Герман Улсад ашиг, хохирлыг нарийвчлаагүй, харин тухайн объектын хүрээнд тайлбарладаг.

Эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашиглах гэмт хэргийн ***хүндрүүлэх нөхцөл*** буюу ял шийтгэлийг чангаруулах асуудлыг улс орнууд өөр өөр хэлбэрээр зохицуулдаг. Зарим улс нь хүндрүүлэх нөхцөлийг шууд заадаг (Казахстан, Солонгос), зарим нь "хүндрүүлэх нөхцөл" заагаагүй боловч заалтын үйлчлэх хүрээг өргөтгөж (Австрали), эсхүл дагалдах эрх зүйн үр дагавраар (Герман) чангаруулж байна. Нийтлэг хандлага нь тус гэмт хэргийг нийгмийн хор уршиг өндөртэй гэж үзэн ял оногдуулах бодлогыг чангаруулах боломжийг хуульчилсан явдал юм:

- Казахстан Улс хүндрүүлэх нөхцөлийг нэлээд нарийвчилан тогтоосон. Төрийн өндөр албан тушаалтан, шүүгч, хууль сахиулагч зэрэг тусгай субъект, бүлгийн ашиг сонирхол, мэдээлэл ашигласан нөхцөл, хүнд хор уршиг үүсгэсэн тохиолдолд ялыг хүндрүүлнэ;
- Солонгос Улсад энэ гэмт хэрэг нь хүнд үр дагавартай байж, бүлэглэлийн ашиг сонирхолд үйлчилсэн, эсхүл онцгой нөхцөлд үйлдэгдсэн тохиолдолд ял шийтгэлийг хүндрүүлэн оногдуулна;
- Австрали Улсад уг зохицуулалтаар нийтийн албан тушаалтан байхаа больсон этгээд ч, албан тушаалтны хувиар үүрэг гүйцэтгэж байхдаа олж авсан мэдээллийг ашиглан бусдад зориуд чиглэсэн үйлдэл хийхийг хамруулах замаар заалтын хүрээг өргөтгөсөн;
- Герман Улс ялын дээд хэмжээг өндөр тогтоох, оролдлогыг шийтгэх, түүнчлэн тодорхой нөхцөлд нийтийн алба эрхлэх эрхийг хасах дагалдах арга хэмжээг хэрэглэж байна.

Хоёр. ЭРХ МЭДЭЛ, АЛБАН ТУШААЛАА УРВУУЛАН АШИГЛАХ НОГДУУЛАХ ЭРҮҮГИЙН БА ЭРҮҮГИЙН БУС ХАРИУЦЛАГА

2.1.Эрүүгийн хариуцлага хүлээлгэх

Төрийн (нийтийн) албан тушаалтны эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашиглах гэмт хэргийн зохицуулалт улс орон бүрийн хууль тогтоомжид харилцан адилгүй хэлбэрээр тусгагдсан байдаг. Энэ судалгаанд Австрали, Казахстан, Солонгос болон Герман зэрэг улсын эрүүгийн хуулиас төрийн (нийтийн) албан тушаалтны эрх мэдлээ урвуулан ашиглах, шударга ёсыг гажуудуулах болон холбогдох гэмт хэрэгт оноох ял шийтгэлийн хүрээг хүснэгтэд нэгтгэн харууллаа.

Хүснэгт 1. Эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашиглах гэмт хэрэгт оноох хариуцлагын харьцуулалт

№	Улс	Эрүүгийн хуулийн заалт	Гэмт хэргийн төрөл	Хорих ял	Торгууль	Эрх хасах	Нэмэлт нөхцөл
1.	Австрали Улс	§142.2	Нийтийн албан тушаалаа урвуулан ашиглах	5 жил хүртэл	-	-	-
2.	Казахстан Улс	§361.1	Нийтийн албан тушаалаа урвуулан ашиглах	2 жил хүртэл	2,000 нэгж хүртэл	Насан туршид	Нийтийн ажил (600 цаг хүртэл), засч залруулах ажил, эд хөрөнгө хураах
		§361.2-1	Хууль сахиулах байгууллагын ажилтан	4 жил хүртэл	4,000 нэгж хүртэл	Насан туршид	Нийтийн ажил (1,000 цаг), эд хөрөнгө хураах
		§361.3	Хариуцлагатай төрийн албан тушаалтан	5 жил хүртэл	5,000 нэгж хүртэл	Насан туршид	Нийтийн ажил (1,200 цаг), эд хөрөнгө хураах
		361.4	Онц нөхцөл (гэмт бүлэг, шүүгч, хууль сахиулах байгууллагын хариуцлагатай албан тушаалтан, хүнд хор уршиг)	7 жил хүртэл	-	Насан туршид	Эд хөрөнгө хураах
3.	Солонгос Улс	§123	Эрх мэдлээ урвуулан ашиглах	5 жил хүртэл	10 сая воноос ихгүй	10 жил хүртэл хугацаагаар эрх хасах	-
4.	Герман Улс	§339	Шүүхийн шударга ёсыг гажуудуулах	1-5 жил	-	Шүүхийн шийдвэрээр нийтийн албан тушаал эрхлэх	-

						эрхийг хасаж болно	
		§344	Гэм буруугүй этгээдийг яллах	1-10 жил (хөнгөнд 3 сар-5 жил)	-	Дээрхтэй адил	-
		§345	Гэм буруугүй этгээдэд шийтгэх шийдвэрийг хууль бусаар гүйцэтгэх	1-10 жил (хөнгөнд 3 сар-5 жил; болгоомжгүй үйлдэлд 1 жил хүртэл эсхүл торгууль)	Болгоомжгүй тохиолдолд торгууль	Дээрхтэй адил	-
		§348	Албан бичиг баримтыг хуурамчаар үйлдэх	5 жил хүртэл	Торгууль	Дээрхтэй адил	-
		§352	Илүү төлбөр, хөлс нэхэмжлэх	1 жил хүртэл	Торгууль	Дээрхтэй адил	-
		§353	Илүү татвар, төлбөр хураах, хууль бусаар хөнгөлөлт бууруулах	3 сар-5 жил	-	Дээрхтэй адил	-
		§358	Нэмэлт эрх зүйн үр дагавар	-	-	6 сараас дээш хугацаагаар хорих ял авсан тохиолдолд нийтийн албан тушаал эрхлэх эрхийг хасч болно	-

Эх сурвалж: Судалгаанд хамрагдсан улсуудын эрүүгийн хуулиудад тулгуурлан судлаачийн боловсруулснаар.

Хүснэгтээс харахад, Австрали болон Солонгос улсад харьцангуй энгийн бүтэцтэй зохицуулалттай бөгөөд үндсэн ял шийтгэл нь хорих ял байна. Австрали Улсын Эрүүгийн хуульд нийтийн албан тушаалтан (мөн албан тушаалаас чөлөөлөгдсөн этгээд) мэдээлэл, нөлөөгөө ашиглан хууль бус ашиг хүртэх, эсхүл бусдад хохирол учруулсан тохиолдолд тав хүртэл жилээр хорих ял оногдуулна (§142.2). Солонгос Улсын Эрүүгийн хуульд эрх мэдлээ урвуулан ашиглах гэмт хэрэгт тав хүртэл жил хорих, арван жил хүртэл тодорхой эрх хасах, эсхүл арван сая воноос ихгүй мөнгөн торгууль оногдуулах байдлаар ял шийтгэл тогтоосон байна (§123).

Казахстан Улсад энэ төрлийн зохицуулалт илүү нарийвчилсан бөгөөд албан тушаалтны ангилал (ердийн, хууль сахиулах байгууллагын ажилтан, хариуцлагатай төрийн албан тушаалтан) болон онц нөхцөлийн ялгаагаар ял шийтгэл өөрчлөгддөг. Мөн зөвхөн хорих ял бус торгууль, нийтийн ажил, засч залруулах ажил зэрэг олон хэлбэрийн ял тогтоож, түүн дээр нэмэлтээр эд хөрөнгө хураах, албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа

явуулах эрхийг насан туршид хасах хатуу зохицуулалттай байгаагаараа онцлог юм (§361).

Герман Улсад нийтийн албан тушаалтны эрх мэдэлтэй холбоотой гэмт хэргийг илүү нарийн ангилалаар авч үздэг бөгөөд шүүхийн шударга ёсыг гажуудуулах (§339), гэм буруугүй этгээдийг яллах (§344), баримт бичгийг хуурамчаар үйлдэх (§348), илүү төлбөр, хөлс нэхэмжлэх (§352), илүү татвар, төлбөр хураах, хууль бусаар хөнгөлөлт бууруулах (§353) зэрэг олон зүйл ангид хуваарилжээ. Эдгээрт оноох ял нь гурван сараас арван жил хүртэл хорих, мөн тодорхой нөхцөлд торгууль ногдуулах боломжтойгоороо ялгардаг. Түүнчлэн дор хаяж зургаан сарын хорих ял авсан тохиолдолд нийтийн албан тушаал эрхлэх эрхийг хасах (Nebenfolgen) нэмэлт хориг хэрэглэгдэх боломжтой байдаг.

2.2.Эрүүгийн бус хариуцлага хүлээлгэх

2.2.1.Австралийн Холбооны Улс

Австрали Улсад нийтийн албан хаагчдын ёс зүй, сахилга, ашиг сонирхлын зөрчлийг *Нийтийн албаны тухай хуулиар*[14] зохицуулдаг. Тус хуулийн 15 дугаар зүйлд Нийтийн албан тушаалтны ёс зүйн дүрэм (Australian Public Service Code of Conduct)-ийг зөрчсөн тохиолдолд сахилгын шийтгэл ногдуулна. Үүнд: сануулах, цалингаас торгууль хэлбэрээр суутгах, цалинг бууруулах, үүрэгт ажлыг өөрчлөх, албан тушаал бууруулах, ажлаас чөлөөлөх багтана.

Мөн хуульд зааснаар Холбооны агентлаг бүр сахилгын журмыг батлах бөгөөд журмыг олон нийтэд нээлттэй нийтэлнэ (§15.3, 15.7).

2.2.2.Бүгд Найрамдах Казахстан Улс

Казахстан Улсад нийтийн албан хаагчдын ёс зүй, сахилга, ашиг сонирхлын зөрчил болон авлигын эсрэг үйл ажиллагааг Нийтийн албаны тухай хууль болон Авлигын эсрэг хуулиар зохицуулдаг.

Нийтийн албаны тухай хууль[15] нь нийтийн албан хаагчийн үүрэг, ёс зүйн зөрчил, сахилгын хариуцлагын үндэслэл, шийтгэлийн хэлбэрийг тодорхойлдог. Тус хуулийн 44 дүгээр зүйлд сахилгын зөрчил гаргасан тохиолдолд дараах шийтгэлүүдийг ногдуулахыг заасан байна. Үүнд: сануулах, хатуу сануулах, ажлын байрны шаардлага хангахгүй байгааг анхааруулах, албан тушаал бууруулах, ажлаас чөлөөлөх.

Эдгээр шийтгэл нь Сахилгын зөвлөл болон Холбооны агентлагийн дэргэдэх сахилгын хорооны санал, дүгнэлтийн үндсэн дээр эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хэрэгждэг.

Сахилгын зөвлөл нь Нийтийн албаны асуудал эрхэлсэн агентлагийн дэргэд ажилладаг бөгөөд нийтийн албан хаагчдын ёс зүй, сахилгын зөрчилд хяналт тавьж, сахилгын шийтгэлийн талаар санал, дүгнэлт гаргах чиг үүрэгтэй. Харин байгууллагын түвшинд ажилладаг сахилгын хороо нь тухайн байгууллагын хүрээнд зөрчлийг хэлэлцэж, санал, дүгнэлт гаргадаг. Мөн уг хуулийн 50-52 дугаар зүйлд заасны дагуу сахилгын шийтгэл хүчинтэй хугацаанд тухайн албан хаагчийг төрийн албанд дахин томилох, дэвшүүлэхийг хориглодог.

[14] Австрали: Public Service Act (1999). Хандах: https://www.legislation.gov.au/C2004A00538/latest/text
[15] Казахстан: Law on the Civil Service (2015). Хандах: https://adilet.zan.kz/rus/docs/Z1500000416?utm

Авлигын эсрэг хууль[16] нь нийтийн албан хаагч авлигын шинжтэй үйлдэл гаргасан бол түүнд захиргааны шийтгэл**,** нийтийн албанд ажиллах эрхийг хасах, мөн дахин ажиллуулахгүй байх нөхцөлийг тогтоодог. Тус хуулийн 15 дугаар зүйлд ашиг сонирхлын зөрчил үүсэх, эсхүл үүсэх нөхцөл бүрдсэн тохиолдолд албан тушаалтанд албан үүргээ хэрэгжүүлэхийг хориглож, зөрчлийг ил тод мэдээлэх, урьдчилан сэргийлэх, зохицуулах үүргийг хуульчилсан. Мөн 16 дугаар зүйлд авлигын гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийтийн болон төрийн өмчит байгууллагад ажиллуулахыг хориглох, сонгуульт албан тушаалд нэр дэвшүүлэхийг хязгаарлах зэрэг авлигын дараах хориг арга хэмжээг тогтоосон байдаг.

2.2.3.Бүгд Найрамдах Солонгос Улс

Солонгос Улсад нийтийн албан хаагчдын ёс зүй, сахилга, ашиг сонирхлын зөрчил болон авлигын эсрэг үйл ажиллагааг Нийтийн албаны тухай хууль, Авлигын эсрэг иргэний эрхийн комисс байгуулах, ажиллуулах тухай хууль болон Нийтийн албаны ёс зүйн тухай хуулиар зохицуулдаг.

Нийтийн албаны тухай хууль[17] нь нийтийн албан хаагчийн үүрэг зөрчил, сахилгын хариуцлагын хэлбэрийг тодорхойлдог. Тус хуулийн 79 дүгээр зүйлд нийтийн албан хаагчид сахилгын шийтгэлийн төрлийг хуульчилсан. Үүнд: сануулах, цалинг бууруулах, ажил үүргээ түр хугацаагаар түдгэлзүүлэх, албан тушаал бууруулах, ажлаас халах, ажлаас чөлөөлөх багтана.

Эдгээр шийтгэлийг Ерөнхийлөгчийн зарлигаар байгуулагдсан Сахилгын хороо (Disciplinary Committee)-ны шийдвэрийн дагуу оногдуулдаг. Тус хорооны бүтэц, бүрэлдэхүүн, эрх хэмжээ, хэлэлцэх журам болон сахилгын шийтгэлд хамаарах этгээдийн сонсголын эрхийг хэрэгжүүлэх асуудлыг Нийтийн албаны тухай хуулийн 81 дүгээр зүйл болон холбогдох Ерөнхийлөгчийн зарлигаар нарийвчлан зохицуулсан.

Авлигын эсрэг иргэний эрхийн комисс байгуулах, ажиллуулах тухай хуулийн[18] 12-13 дугаар зүйлд зааснаар тус комисс нь авлигын шинжтэй үйлдлийг шалгах, ёс зүйн зөрчил илрүүлэх, сахилгын шийтгэл санал болгох бүрэн эрхтэй. Тус байгууллага нь нийтийн албанд итгэлцэл, хариуцлагыг бэхжүүлэх чиг үүрэг бүхий төв байгууллага юм.

Нийтийн албаны ёс зүйн тухай хууль[19] нь нийтийн хаагчийн ёс зүйн үүрэг, ашиг сонирхлын зөрчил, хөрөнгө орлого мэдүүлэх журмыг тодорхойлж, албан тушаал, эрх мэдлээ хувийн ашиг сонирхолд ашиглахыг хориглодог. Мөн тус хуулийн 17 дугаар зүйлд (Restriction on Employment of Retired Public Officials) энэ хуулийг зөрчсөн, ёс зүйн болон авлигын шинжтэй үйлдэл гаргасан албан хаагчид:

- ажлаас халах;
- албан тушаалаас чөлөөлөх шийтгэл ногдуулж болох бөгөөд тухайн этгээдийг тодорхой хугацаанд нийтийн албанд дахин ажиллуулахыг хориглохоор заасан.

Хуулийн 18 дугаар зүйлд (Confirmation on Whether Employment is Restricted and Approval of Employment) ёс зүйн зөрчил гаргасан албан хаагчийн дахин ажилд орох эрхтэй эсэхийг тодорхойлох, хянан шийдвэрлэх журмыг Ерөнхийлөгчийн зарлигаар нарийвчлан тогтоохыг хуульчилсан.

---

[16] Казахстан: О противодействии коррупции (2015). Хандах:https://adilet.zan.kz/rus/docs/Z1500000410
[17] Солонгос: State Public Officials Act (2018).Хандах: https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=49778&lang=ENG&utm
[18] Солонгос: Act on Anti-Corruption and the Establishment and Operation of the Anti-Corruption and Civil Rights Commission (2008). Хандах: https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=62479&lang=ENG
[19] Солонгос: Public Service Ethics Act (2017). Хандах: https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=45491&lang=ENG

2.2.4.Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Герман Улсад нийтийн албан хаагчдын сахилгын болон ёс зүйн хариуцлагыг *Холбооны сахилгын тухай хуулиар*[20] зохицуулдаг. Энэ хууль нь холбооны түвшний нийтийн албан хаагч (Beamte des Bundes) ёс зүйн болон албан үүргийн зөрчил гаргасан тохиолдолд хүлээлгэх сахилгын шийтгэл, хэрэглэх журмыг заасан байдаг. Тус хуулийн 5-13 дугаар зүйлд сахилгын шийтгэлүүдийг хуульчилсан. Үүнд: сануулах, мөнгөн торгууль ногдуулах, цалинг бууруулах, албан тушаал бууруулах, албанаас чөлөөлөх.

Эдгээр сахилгын шийтгэл нь нийтийн албан үүргээ ноцтой зөрчсөн, ёс зүйн хэм хэмжээг алдагдуулсан, эсхүл төрийн албан хаагчийн нэр хүндэд сөргөөр нөлөөлөх үйлдэл гаргасан тохиолдолд хэрэглэгддэг. Холбооны сахилгын тухай хуульд заасан дээр дурдсан сахилгын шийтгэлийг хэрэглэх, шийтгэлийн төрлийг сонгох, хэрэгжилтийг хянах бүрэн эрхийг Сахилгын байгууллага (Disziplinarbehörde) хэрэгжүүлдэг (§33-§35). Мөн уг хуульд зааснаар, зарим сахилгын зөрчил нь эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжтэй байж болох бөгөөд эрүүгийн хэрэг үүсгэсэн болон эрүүгийн хариуцлага хүлээсэн нь сахилгын ажиллагаа явуулахад саад болох үндэслэл болохгүй (§14).

2.3.Хоёрдугаар бүлгийн үр дүн

Судалгаанд хамрагдсан Австрали Улс, Казахстан Улс, Солонгос Улс, Герман Улс нь эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашиглахтай тэмцэхдээ эрүүгийн болон эрүүгийн бус (ёс зүй, сахилга) хоёр түвшний уялдсан тогтолцоог хэвшүүлсэн байна. Энэ нь гэмт хэрэгт хариуцлага тооцох хатуу арга хэмжээг ёс зүй, сахилгын хяналттай уялдуулснаар нийтийн албанд хариуцлага, ил тод байдлыг зэрэг бэхжүүлэх зорилготой юм.

Эрүүгийн хариуцлагын хүрээнд эдгээр улсууд ял шийтгэл, субъект, онц нөхцөл, нэмэлт хориг арга хэмжээгээрээ ялгаатай бүтэцтэй байна. Австрали Улсад эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашиглах гэмт үйлдэлд дээд тал нь таван жил хүртэл хорих ял оногдуулна (§142.2). Солонгос Улсад таван жил хүртэл хорих, эсхүл арван жил хүртэл эрх хасах, эсхүл арван сая воноос ихгүй торгууль ногдуулна (§123). Казахстан Улсад хоёр жилээс долоон жил хүртэл хорих буюу эрх чөлөөг хязгаарлахыг субъект ба онц нөхцлөөс хамааруулан шатлан тогтоосон (§361.1-4). Харин Герман Улсад нэгээс арван жил хүртэл хорих ял оноох бөгөөд гэмт хэргийн төрлөөр ангилсан (§339, §344, §345, §348, §352, §353, §358).

Эдгээр улсуудад энэ гэмт үйлдлийг төрөл, субъект, онц нөхцөлөөр ялган ял оногдуулдаг. Тухайлбал, Казахстан, Герман улсад албан тушаалтны ангилал (жишээлбэл, хууль сахиулах ажилтан, шүүгч) болон онц нөхцөлийг тусад нь авч үзэн, ялыг шатлан нэмэгдүүлэхээр зохицуулсан байна. Харин Австрали, Солонгос улсад нэгтгэсэн буюу нэг зүйл ангид төвлөрсөн зохицуулалт хэрэглэдэг. Энэ ялгаа нь Казахстан, Герман улсад эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, татвар, төлбөрийн зохицуулалт, баримт бичгийн үнэн зөв байдлыг хамгаалах тусгай хяналт илүү хүчтэй байгааг харуулж байна.

Эрүүгийн хариуцлагын нэмэлт үр дагаврын хувьд, Казахстан Улсад эд хөрөнгө хураах, нийтийн албанд дахин ажиллах эрхийг насан туршид хасах хатуу хориг хэрэглэхээр хуульчилсан. Герман Улсад дор хаяж зургаан сарын хорих ял авсан тохиолдолд шүүхээс нийтийн албан тушаал эрхлэх эрхийг хасч болох нэмэлт хориг

[20] Герман: Bundesdisziplinargesetz, BDG (2024). Хандах: https://www.gesetze-im-internet.de/bdg/

үйлчилдэг. Австрали, Солонгост нэмэлт үр дагавар харьцангуй хязгаарлагдмал бөгөөд хорих ялаас гадна эрх хасах болон торгуулийн арга хэмжээ хэрэглэдэг.

Эрүүгийн бус буюу ёс зүйн, сахилгын хариуцлагын хүрээнд эдгээр улсуудад төрийн (нийтийн) албан хаагчийн ёс зүйн болон үүргийн зөрчилд сахилгын шийтгэлийг шат дараатайгаар хэрэгжүүлэх нь нийтлэг байна. Дөрвөн улсад сануулах, албан тушаал бууруулах, албан тушаал/ажлаас чөлөөлөх арга хэмжээг нийтлэг байдлаар хэрэгжүүлж байна. (Хүснэгт 2.)

Эдгээр улсуудын ялгаатай тал нь сахилгын шийтгэл гаргах журам, хяналт тавих байгууллагын бүтэц, шийтгэлийн арга хэмжээний хүрээнд илэрдэг. Австрали Улсад Холбооны агентлаг бүр өөрийн сахилгын журмыг бичгээр баталж, олон нийтэд нээлттэй байлгах үүрэгтэй байдаг тул ил тод байдал сайн хангагдсан. Казахстан Улсад сахилгын зөрчлийг Сахилгын зөвлөл болон байгууллагуудын дэргэдэх хороод хэлэлцэж шийдвэр гаргадаг бөгөөд сахилгын шийтгэл хүчинтэй байх хугацаанд тухайн хүнийг нийтийн албанд дахин томилох, дэвшүүлэхийг хориглодог. Солонгос Улсад Ерөнхийлөгчийн зарлигаар байгуулагдсан Сахилгын хороо сахилгын шийтгэлийг шийдвэрлэдэг бөгөөд “ажлын үүргээ түр хугацаагаар түдгэлзүүлэх” гэсэн тусгай хэлбэрийг хэрэглэдэг. Мөн Нийтийн албаны ёс зүйн хуулиар “ажлаас гарснаас хойших хязгаарлалт” буюу тодорхой хугацаанд нийтийн албанд дахин ажиллуулахыг хориглох, эсхүл зөвшөөрлөөр шийдэх журам үйлчилдэг. Герман Улсад сахилгын байгууллага бие даан ажиллаж, эрүүгийн хэрэгтэй зэрэгцүүлэн сахилгын ажиллагааг тасралтгүй явуулдаг. Энэ нь албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг тогтвортой баримтлах, сахилгын зөрчлийг байнга хянах нөхцөлийг бүрдүүлдэг байна.

Хүснэгт 2. Төрийн (нийтийн) албан хаагчийн эрүүгийн бус хариуцлагын харьцуулалт

№	Сахилгын арга хэмжээ	Австрали Улс	Казахстан Улс	Солонгос Улс	Герман Улс
1.	Сануулах	+	+	+	+
2.	Албан тушаал бууруулах	+	+	+	+
3.	Албан тушаал/ажлаас чөлөөлөх	+	+	+	+
4.	Цалинг бууруулах	+		+	+
5.	Цалингаас мөнгөн торгууль ногдуулах	+			+
6.	Хатуу сануулах		+		
7.	Үүрэгт ажлыг өөрчлөх	+			
8.	Ажлын байрны шаардлага хангахгүй байгааг анхааруулах		+		
9.	Ажил үүргээ түр хугацаагаар түдгэлзүүлэх			+	

Эх сурвалж: Судалгаанд хамрагдсан улсуудын холбогдох хуулиудад тулгуурлан судлаачийн боловсруулснаар.

Гурав. ХУУЛЬ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД

3.1.Мөрдөн шалгах ажиллагаа ба авлигатай тэмцэх тусгай байгууллага

3.1.1.Австралийн Холбооны Улс

Авлигын эсрэг үндэсний комисс (National Anti-Corruption Commission) нь 2022 оны *Авлигын эсрэг үндэсний комиссын тухай хуулийн*[21] дагуу байгуулагдсан байна. Комисс нь нийтийн албанд холбогдох ноцтой, тогтолцооны шинжтэй авлигын хэргийг шалгах, урьдчилан сэргийлэх, бодлогын зөвлөмж гаргах бие даасан байгууллага (§10-15) бөгөөд 2022 онд байгуулагдсан байна.

Комиссын үйл ажиллагаанд Парламентын хамтарсан хороо (Parliamentary Joint Committee) хяналт тавьдаг бөгөөд хорооны чиг үүргийг тус хуулийн 177 дугаар зүйлд тодорхойлсон (Parliament of Australia, n.d.).

Комиссын үндсэн чиг үүрэг нь Холбооны нийтийн албанд холбогдох ноцтой, тогтолцооны шинжтэй авлигын асуудлыг шалгах, үр дүнг тайлагнах, бодлогын зөвлөмж гаргах бөгөөд шалгалтын дүн, нотлох баримтыг прокурорт ашиглуулах, шилжүүлэхийг уг хуулийн 99-109 дүгээр зүйлд нарийвчлан зохицуулсан.

Авлигын эсрэг үндэсний комисс нь ***Австралийн Холбооны цагдаатай*** (Australian Federal Police) хамтран ажиллаж, мөрдөн шалгалтын дүнг прокурорт шилжүүлэх зохицуулалттай (Australian Federal Police, 2025).

3.1.2.Бүгд Найрамдах Казахстан Улс

Авлигын эсрэг алба (Anti-Corruption Service) нь *Авлигын эсрэг хуульд*[22] зааснаар төрийн байгууллагын хүрээнд авлигын гэмт хэрэг, үүнд, албан тушаалаа урвуулан ашиглах хэргийг таслан зогсоох, мөрдөн шалгах чиг үүрэгтэй бөгөөд прокурорын хяналтад ажилладаг (§190.1).

3.1.3.Бүгд Найрамдах Солонгос Улс

Өндөр албан тушаалтны авлигын хэргийг мөрдөн шалгах газар (Corruption Investigation Office for High-Ranking Officials) нь өндөр түвшний албан тушаалтнууд болон тэдний гэр бүлийн гишүүдтэй холбоотой авлигын болон албан тушаалын гэмт хэргийг мөрдөн шалгах чиг үүрэгтэй.

Өндөр албан тушаалтны авлигын хэргийг мөрдөн шалгах газар байгуулах, үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн[23] дагуу байгуулагдсан тус газар нь (а) өндөр албан тушаалтны авлигын хэрэг, түүнтэй холбоотой хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах, (б) тодорхой өндөр албан тушаалтнууд (Үндсэн хуулийн шүүхийн гишүүн, Ерөнхий прокурор, шүүгч, прокурор, цагдаагийн дээд албан тушаалтан гэх мэт) болон тэдний гэр бүлийн гишүүдийн холбогдох хэргийг прокурорын байгууллагаас үл хамааран бие даан яллах, яллах ажиллагааг үргэлжлүүлэх бүрэн эрхтэй (§2, 3).

Өндөр албан тушаалтны авлигын хэргийг мөрдөн шалгах газар нь өөрийн чиг үүргээ бие даан хэрэгжүүлэх бөгөөд тус улсын Ерөнхийлөгч, түүний Тамгын газрын

[21] Австрали: National Anti-Corruption Commission Act (2022). Хандах: https://www.legislation.gov.au/C2022A00088/latest/text
[22] Казахстан: On combating corruption (2015). Хандах: https://adilet.zan.kz/eng/docs/Z1500000410
[23] Солонгос: Act on the establishment and operation of the corruption investigation office for high-ranking officials (2020). Хандах: https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=53133&key=5&type=part

албан тушаалтнууд үйл ажиллагаанд нь оролцож, тайлан шаардах, заавар өгөх, санал гаргах, зөвшилцөхийг хориглодог (§3.2-3).

Тус газар нь яллах ажиллагааг дангаар гүйцэтгэхгүй бөгөөд хуулиар прокурорын байгууллагад хэрэг, материал шилжүүлэх, эсхүл прокурортой уялдаатайгаар хэрэг хянан шийдвэрлүүлэх механизмыг давхар тогтоосон. Тухайлбал, тус газар нь өндөр албан тушаалтантай холбоотой онцгой хэрэгт өөрөө яллах ажиллагаа явуулах боломжтой ч, өөр ангиллын, эсхүл түүний яллах харьяаллаас гадуур үлдэх хэргүүдийг Ерөнхий прокурорын байгууллагад шилжүүлнэ (§24-26).

Харин ***Авлигын эсрэг иргэний эрхийн комисс*** (Anti-Corruption and Civil Rights Commission) нь *Авлигын эсрэг иргэний эрхийн комиссын тухай хуульд*[24] зааснаар ёс зүй, урьдчилан сэргийлэх бодлого хэрэгжүүлэх, мэдээлэл, гомдол хүлээн авах, мэдээлэгчийг хамгаалах чиг үүрэгтэй (§12).

3.1.4.Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Герман Улсад авлигын болон нийтийн албан тушаалтай холбоотой гэмт хэргийг тусгайлан шалгах бие даасан байгууллага байхгүй. Холбогдох хэргийг ***цагдаагийн байгууллага*** шалгаж, прокурор хяналт тавьдаг. Авлигын эсрэг бодлого, ёс зүйн хяналт нь ***Холбооны Дотоод хэргийн яам*** (Federal Ministry of the Interior and Community)-аар дамжин хэрэгждэг бөгөөд нийтийн албаны дотоод хяналтын тогтолцоонд багтдаг байна (Federal Ministry of the Interior and Community, 2025).

3.2.Прокурорын хяналт ба удирдамжийн цар хүрээ

3.1.1.Австралийн Холбооны Улс

Австрали Улсын Ерөнхий прокурор газрын ***Захирлын алба*** (Office of the Director of Public Prosecutions) *Нийтийн яллах газрын захирлын газрын тухай хуулийн*[25] 6 дугаар зүйлд заасны дагуу мөрдөн шалгах байгууллагуудаас (Австралийн Холбооны цагдаа, Авлигын эсрэг үндэсний комисс) шилжүүлсэн хэргийг хянаж, нотлох баримтын хангалт, нийтийн ашиг сонирхолд нийцэх эсэхийг үнэлж яллах шийдвэр гаргаж, шүүхэд төлөөлдөг.

3.1.2.Бүгд Найрамдах Казахстан Улс

Прокурорын байгууллагын тухай үндсэн хуульчлагдсан хууль[26] болон *Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар*[27] ***Ерөнхий прокурорын газар*** (Prosecutor General's Office) нь нь улсын нутаг дэвсгэрт хууль дээдлэх зарчмын хэрэгжилт, хууль ёсны байдлыг хангах, түүний сахин биелэлтэд улсын нэрийн өмнөөс дээд хяналт тавих үүрэгтэй байгууллага юм (Prosecutor General’s Office, (n.d.)). Прокурорын байгууллагын тухай үндсэн хуульчлагдсан хуулийн 10 дугаар зүйлд зааснаар прокурор нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавих, яллах дүгнэлт гаргах, шүүхэд шилжүүлэх эрхтэй.

---

[24] Солонгос: Anti-Corruption and Civil Rights Commission Act (2023). Хандах: https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?

[25] Австрали: Director of Public Prosecutions Act (1983). Хандах: https://www.legislation.gov.au/C2004A02830/latest/text

[26] Казахстан: Конституционный закон Республики Казахстан ‘’О прокуратуре’’ (2022). Хандах: https://adilet.zan.kz/rus/docs/Z2200000155

[27] Казахстан: Criminal Procedure Code of the Republic of Kazakhstan (2014). Хандах: https://adilet.zan.kz/eng/docs/K1400000231/info

Ерөнхий прокурорын газар нь эрүүгийн хэргийг мөрдөн шалгах ажиллагаагаа ***Цагдаагийн Гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс*** (Department of Criminal Police) болон ***Авлигын эсрэг агентлаг*** (Anti-Corruption Agency of the Republic of Kazakhstan)-тай хамтран хэрэгжүүлдэг.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар Гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс нь хэрэг бүртгэх, нотлох баримт цуглуулах, сэжигтнийг саатуулах, хэргийг прокурорт шилжүүлэх үүрэгтэй бөгөөд бүх ажиллагаа прокурорын хяналтад явагддаг (§7, 184-190).

Гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс нь нийтлэг эрүүгийн хэргийг шалгадаг бол Авлигын эсрэг агентлаг нь Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу авлигын шинжтэй гэмт хэргийг таслан зогсоох, мөрдөн шалгах чиг үүргийг мэргэшсэн байдлаар хэрэгжүүлдэг.

3.1.3.Бүгд Найрамдах Солонгос Улс

Солонгос Улсын ***Улсын Дээд прокурорын газар*** (Supreme Prosecutors' Office) нь *Прокурорын тухай хууль*[28] (§4-1) болон *Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль*[29] (§195-199)-ийн дагуу эрүүгийн хэрэг үүсгэх, мөрдөн шалгах ажиллагаанд хяналт тавих, яллах дүгнэлт гаргах, шүүхэд төрийн төлөөлөгчөөр оролцох бүрэн эрхтэй. Мөн тус хуульд прокурор нь цагдаагийн мөрдөн шалгах ажиллагааг удирдан чиглүүлэх үүрэгтэй (§196) гэж заасан нь тус улсын эрүүгийн эрх зүйн тогтолцооны онцлог шинжийг илэрхийлдэг.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2020-2022 онд шинэчлэгдсэний дараа прокурорын байгууллага нь хэргийг шүүхэд шилжүүлэх эсхүл хэрэгсэхгүй болгох шийдвэр гаргах эрхээ хадгалсан боловч цагдаагийн байгууллагыг шууд командлан удирдах эрх хэмжээ хязгаарлагдсан. Харин прокурор нь тодорхой нөхцөлд дахин шалгуулах буюу мөрдөх ажиллагааг иж бүрэн явуулахыг шаардах хэлбэрээр хяналтаа хэрэгжүүлэх механизмыг ашигладаг болсон. Энэ зохицуулалт нь мөрдөн ба яллах шатны уялдаа холбоог илүү хоёр шаттай, шүүлтүүртэй болгож, эрх мэдлээ урвуулан ашиглах, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх институцийн зохицуулалт болж байна (Library of Congress (U.S.), 2023).

3.1.4.Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Холбооны Прокурорын газар (Federal Prosecutor's Office) нь эрүүгийн хэрэг үүсгэх, мөрдөн шалгах ажиллагаанд хяналт тавих, нотлох баримт цуглуулах, яллах дүгнэлт гаргах чиг үүрэгтэй. *Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн*[30] (§170)-д зааснаар нотлох баримт хангалттай бол шүүхэд шилжүүлэх, хангалтгүй бол хэрэгсэхгүй болгоно гэж заасан. Германд прокурорын байгууллага нь мөрдөн шалгах ажиллагаанд шууд удирдамж өгөх эрхтэй бөгөөд энэ нь хууль хэрэгжүүлэгч байгууллагуудын уялдаа, хяналтын тэнцвэрийг хангахад чиглэсэн.

Түүнчлэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 160, 161, 163 дугаар зүйлд прокурор нь мөрдөн шалгах ажиллагааг удирдах эрхтэй бөгөөд цагдаагийн

[28] Солонгос: Prosecutors' office act (2017). Хандах: https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=42630&lang=ENG&utm
[29] Солонгос: Criminal procedure act (2009). Хандах: https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?lang=ENG&hseq=22535
[30] Герман: German Code of Criminal Procedure (1987). Хандах: https://www.gesetze-im-internet.de/englisch_stpo/?utm

байгууллага прокурорын заавар, хүсэлтийг биелүүлэх үүрэгтэй гэж заасан. Харин 170 дугаар зүйлд, хэргийн нотлох баримт хангалттай тохиолдолд прокурор яллах шийдвэр гаргах, хангалтгүй бол хэргийг хэрэгсэхгүй болгох эрхтэй гэж хуульчилсан байдаг.

Эдгээр зохицуулалт нь авлига болон эрх мэдлээ урвуулсан гэмт хэргүүдийн хувьд мөрдөн байцаах ба яллах шатны ажиллагааг нэгтгэж, прокурорт нотлох баримтын чанарт шууд хяналт тавих нөхцөлийг бүрдүүлдэг (Germany. Federal Ministry of Justice, 2024).

Холбооны Эрүүгийн Цагдаагийн газар (Federal Criminal Police Office-BKA) нь *Холбооны Эрүүгийн Цагдаагийн газрын тухай хуулийн*[31] 4 дүгээр зүйлд зааснаар холбооны хэмжээнд хамаарах эрүүгийн хэргийг мөрдөн шалгах зэрэг чиг үүргийг заасан. Тэр дундаа авлига, нийтийн албан тушаалтны гэмт хэрэг, мөнгө угаах зэрэг хүнд болон олон улсын шинжтэй хэргийг хариуцан шалгадаг.

Цагдаагийн байгууллагын эрүүгийн хэрэг мөрдөн шалгах ажиллагаа нь *Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд*[32] зааснаар прокурорын хяналтад явагдана. Цагдаагийн байгууллага прокурорын заавар, шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй бөгөөд мөрдөн шалгах явцад олж авсан бүх баримтыг нэн даруй прокурорын байгууллагад хүргүүлэх үүрэгтэй (§163(2)).

3.3.Гуравдугаар бүлгийн үр дүн

Судалгаанд хамрагдсан улс орнуудын туршлагаас үзэхэд, авлигын болон эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашиглах гэмт хэрэгт мөрдөн шалгах, яллах ажиллагааг хэрэгжүүлэх эрх зүйн тогтолцоо нь тухайн улсын төрийн байгууллын бүтэц, төвлөрлийн түвшин, прокурорын байгууллагын байр сууринаас хамаарч ялгаатай байна. Гэсэн ч эдгээр улсад мөрдөн шалгах ба яллах ажиллагаа нь хуульд тодорхой заасан байгууллагуудын уялдаа, хяналтын тогтолцоонд тулгуурладаг нийтлэг шинжтэй байна.

Австрали Улс Авлигын эсрэг үндэсний комиссоор дамжуулан авлигын томоохон хэрэгт төвлөрч, урьдчилан сэргийлэх ба бодлогын зөвлөмжийн чиг үүргийг хослуулж байна. Казахстан Улсад Авлигын эсрэг алба прокурорын хяналт дор төвлөрсөн бүтэцтэй ажиллаж байна. Солонгос Улс өндөр албан тушаалтны авлигын хэргийг дагнан шалгах байгууллага байгуулснаараа институцийн бие даасан байдал, улс төрийн нөлөөнөөс ангид байдлыг онцолжээ. Харин Герман Улс тусгай авлигын эсрэг байгууллага байгуулаагүй, харин хууль тогтоомжийн тогтвортой байдал, прокурор-цагдаагийн уялдаа холбоонд тулгуурлаж байна.

Прокурорын байгууллагын хувьд, Австрали болон Герман улсад яллах ажиллагааг хэрэгжүүлж, мөрдөх ажиллагааг чиглүүлэх эрх мэдэлтэй; Казахстан Улсад прокурорын өвөрмөц төвлөрсөн хяналт давамгайлсан; харин Солонгос Улсад сүүлийн шинэчлэлээр прокурорын эрхийг шүүлтүүртэй, хязгаарлагдсан байдлаар хэрэгжүүлдэг болсон.

Цагдаагийн байгууллагын оролцоо ч улс бүрт харилцан адилгүй байна. Австралид Холбооны цагдаа Авлигын эсрэг үндэсний комисстой уялдан ажилладаг бол Казахстан Улсад прокурорын шууд удирдлага дор мөрдөн шалгалт явуулдаг. Солонгос Улсад цагдаагийн ажиллагаанд прокурор шууд командлах эрхгүй болж, харин давхар хяналт, дахин шалгуулах механизм ашиглагдаж байна. Харин Герман Улсын Цагдаагийн байгууллага нь бусад авлигын тусгай байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлдэг онцлогтой.

[31] Герман: Bundeskriminalamtgesetz, BKAG (2009). Хандах: https://www.gesetze-im-internet.de/bkag_2018/
[32] Герман: Strafprozessordnung, StPO (1987). Хандах: https://www.gesetze-im-internet.de/stpo/

Хүснэгт 3. Хууль хэрэгжүүлэгч байгууллагуудын харьцуулалт

№	Улс	Мөрдөн шалгалт		Прокурорын хяналт
		Авлигатай тэмцэх тусгай байгууллагын чиг үүрэг	**Цагдаагийн байгууллагын оролцоо**	
1.	Австрали Улс	**Авлигын эсрэг үндэсний комисс:** нийтийн албанд холбогдох ноцтой, тогтолцооны шинжтэй авлигын хэргийг шалгах, урьдчилан сэргийлэх, бодлогын зөвлөмж гаргах. Комиссын үйл ажиллагаанд Парламентын хамтарсан хороо хяналт тавьдаг.	**Австралийн Холбооны цагдаа (AFP):** Авлигын эсрэг үндэсний комисстой уялдаж шалгалт явуулж, дүнгээ прокурорт шилжүүлнэ.	**Нийтийн яллах газрын Захирлын алба (ODPP):** мөрдөн байгууллагаас иргүүлсэн хэргийг нотлох баримтын хангалт, нийтийн ашиг сонирхолд нийцэлтээр үнэлж яллах ба шүүхэд төлөөлөх.
2.	Казахстан Улс	**Авлигын эсрэг алба:** авлигын гэмт хэрэг таслан зогсоох, мөрдөн шалгах чиг үүрэгтэй. Прокурорын хяналтад ажилладаг.	**-**	**Ерөнхий прокурорын газар:** эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавих, яллах дүгнэлт гаргаж шүүхэд шилжүүлнэ. Мөрдөн шалгах ажиллагааг **Цагдаагийн гэмт хэрэгтэй тэмцэх газар** болон **Авлигын эсрэг алба**тай хамтран хэрэгжүүлдэг.
3.	Солонгос Улс	**Өндөр албан тушаалтны авлигын хэргийг мөрдөн шалгах газар:** өндөр түвшний албан тушаалтнууд болон тэдний гэр бүлийн гишүүдтэй холбоотой авлигын болон албан тушаалын гэмт хэргийг мөрдөн шалгана. **Авлигын эсрэг иргэний эрхийн комисс:** урьдчилан сэргийлэх, мэдээлэгчийг хамгаалах, гомдол хүлээн авах чиг үүрэгтэй.	**-**	**Улсын Дээд прокурорын газар:** эрүүгийн хэрэг үүсгэх, хяналт тавих, яллах дүгнэлт гаргах, шүүхэд төрийн төлөөлөгчөөр оролцох бүрэн эрхтэй.
4.	Герман Улс	**Авлигын тусгай байгууллага байхгүй.**	**Цагдаагийн байгууллага:** авлигын болон нийтийн албан тушаалтны гэмт хэргийг хянан шалгана. **Холбооны Дотоод хэргийн яам:** авлигын эсрэг бодлого, ёс зүйн хяналтыг хэрэгжүүлдэг.	**Холбооны Прокурорын газар:** мөрдөн шалгах ажиллагааг удирдах, зааварчилга өгөх; нотлох баримт хангалттай бол яллах, хангалтгүй бол хэрэгсэхгүй болгох. Мөн **Холбооны Эрүүгийн Цагдаагийн газар:** холбооны хэмжээнд болон хүнд, олон улсын шинжтэй хэргийг мөрдөн шалгах; прокурорын шууд удирдамж дор ажиллана.

Эх сурвалж: Судалгаанд хамрагдсан улсуудын холбогдох хуулидад тулгуурлан судлаачийн боловсруулснаар.

Судалгаанаас харахад, эдгээр улсын эрх зүйн зохицуулалт нь өөр өөр институцийн бүтцэд тулгуурладаг ч мөрдөн шалгах ба яллах ажиллагаанд прокурорын хяналтыг заавал хэрэгжүүлэх, нотлох баримтыг хууль ёсны дагуу цуглуулах, хэргийг шүүхэд шилжүүлэх шат дамжлагыг тодорхой тогтоох нийтлэг зарчим үйлчилж байна. Мөн авлигын шинжтэй гэмт хэргийг мэргэшсэн байгууллага шалгах, мөрдөн шалгах ба яллах шат хооронд уялдаа бүхий хяналтын тогтолцоо бүрдүүлэх хандлага түгээмэл байна.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Судалгаагаар Австрали, Герман, Казахстан, Солонгос Улс орнуудын эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашиглах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтийн тогтолцоо, хариуцлагын хэлбэрийг харьцуулан судаллаа. Эдгээр орнуудын тогтолцоонд хууль дээдлэх зарчим нийтлэг үйлчилж, эрүүгийн хариуцлагын хатуу бодлого, ёс зүйн хяналт, хяналт-тэнцвэрийн тогтолцоо зэрэг гурван түвшний арга хэрэгжиж байна.

Эрүүгийн эрх зүйн зохицуулалт: Бүх оронд эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашиглах үйлдлийг нийтийн итгэлцлийг алдагдуулдаг, авлигын шинжтэй ноцтой гэмт хэрэгт тооцдог. Эрүүгийн хуульд субъект нь нийтийн албан тушаалтан байхыг шаарддаг бөгөөд эрх мэдлээ хувийн ашиг сонирхолд ашиглах, хууль бус шийдвэр гаргах, хохирол учруулах зэрэг үйлдлийг гэмт хэргийн бүрэлдэхүүнд хамааруулдаг. Герман Улсад уг гэмт хэргийг шударга ёсыг алдагдуулах, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, хэт өндөр төлбөр ногдуулах гэх мэт тусгай зүйл ангид задлан нарийн заасан нь онцлог юм. Казахстан Улсад төрийн албан тушаалын шатлал, эрх хэмжээний түвшнээс шалтгаалан ял шийтгэл тогтоодог төвлөрсөн бүтэцтэй зохицуулалт үйлчилдэг. Австрали, Солонгос Улсад уг гэмт хэргийг “public office misconduct” болон “abuse of official authority” нэрээр ерөнхий утгаар хуульчилж, нийтлэг бүрэлдэхүүн бүхий заалт ашигладаг.

Хариуцлагын бодлого ба ял шийтгэлийн хүрээ: Судлагдсан орнуудад хорих ял голлох шийтгэл байна. Австрали болон Герман улсад тав хүртэл жил, Казахстан болон Солонгос улсад 10-15 жил хүртэл хорих ял оноох боломжтой. Казахстан Улсад нэмэлтээр эд хөрөнгө хураах, нийтийн албанд ажиллах эрхийг насан туршид хасах шийтгэл хэрэглэж болох бол Германд зургаан сараас дээш ял авсан этгээдэд нийтийн албанд ажиллах эрхийг автоматаар хасдаг. Эдгээр зохицуулалтаас харахад, авлига, албан тушаалын гэмт хэрэгт хариуцлагын бодлого харилцан адилгүй ч төрийн (нийтийн) албаны ёс зүй, нийгмийн итгэлцлийг хамгаалахад чиглэж байна.

Ёс зүйн болон сахилгын хариуцлага: Бүх оронд эрүүгийн хариуцлагатай зэрэгцэн ёс зүйн болон сахилгын хариуцлагын тогтолцоо хэрэгждэг. Австрали Улсад албан тушаалтны ёс зүйн зөрчлийг агентлагийн түвшинд шийдвэрлэдэг бөгөөд сануулах, цалин бууруулах, ажлаас чөлөөлөх шийтгэл хэрэглэнэ. Казахстан Улсад ёс зүйн хороо, сахилгын зөвлөл ажиллаж, ашиг сонирхлын зөрчил гаргасан этгээдэд албан тушаал бууруулах, ажлаас чөлөөлөх шийтгэл ногдуулдаг. Солонгос Улсад Авлигын эсрэг иргэний эрхийн комисс болон Сахилгын хороо урьдчилан сэргийлэх, ёс зүйн хяналт хэрэгжүүлдэг. Герман Улсад Холбооны сахилгын тухай хуулиар ёс зүйн хяналт, сахилгын арга хэмжээг нэг тогтолцоонд уялдуулан хэрэгжүүлдэг нь төрийн албаны хариуцлагыг тогтвортой байлгахад чиглэж байна.

Мөрдөн шалгах бүтэц ба прокурорын хяналт: Хууль хэрэгжилтийн байгууллагын бүтэц улс бүрт ялгаатай ч прокурорын байгууллага голлох үүрэгтэй байна. Австрали Улсад Авлигын эсрэг үндэсний комисс холбооны түвшинд бие даан мөрдөн шалгах чиг үүрэг хэрэгжүүлж, дүнг прокурорт шилжүүлдэг. Казахстан Улсад Ерөнхий прокурорын газар дээд хяналт хэрэгжүүлж, мөрдөн шалгах ажиллагааг Гэмт хэрэгтэй тэмцэх газар болон Авлигын эсрэг алба гүйцэтгэдэг. Солонгос Улсад прокурор нь эрүүгийн хэрэг үүсгэх, яллах дүгнэлт гаргах, цагдаагийн мөрдөн шалгах ажиллагаанд удирдамжаар хяналт тавих үүрэгтэй бөгөөд өндөр албан тушаалтны хэргийг тусгай байгууллага шалгадаг. Герман Улсад мөрдөн шалгах ажиллагаа цагдаагийн байгууллагаар хэрэгжиж, прокурор шууд заавар өгөх эрхтэй байдаг.

Хандлага ба нийтлэг зүй тогтол: Харьцуулсан судалгаанаас үзэхэд, эдгээр оронд эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашиглах гэмт хэрэгтэй тэмцэх бодлого гурван

нийтлэг чиглэлд илэрч байна. Нэгдүгээрт, эрүүгийн хуулиар хатуу хариуцлага тогтоож, нотлох баримтын хууль ёсны байдлыг хангах хяналтын тогтолцоо хэрэгжүүлдэг. Хоёрдугаарт, төрийн (нийтийн) албаны ёс зүй, ил тод байдал, дотоод хяналтыг төрийн байгууллагын хэмжээнд хөгжүүлдэг. Гуравдугаарт, прокурорын хяналт болон парламентын хяналтыг хослуулсан, хариуцлагын ил тод тогтолцоо бүрдүүлсэн байна.

НОМ ЗУЙ

Federal Ministry of the Interior and Community. (2025). *Preventing Corruption and Promoting Ethics in Public Service*. Retrieved from Federal Ministry of the Interior and Community: https://www.bmi.bund.de/EN/topics/modern-state/integrity-initiative/integrity-initiative-node.html

Supreme Court of the Republic of Korea. (2019, 2019 24). *Abuse of official authority case*. Retrieved from Law.go.kr: https://www.law.go.kr/LSW/precInfoP.do?precSeq=206671

Federal Ministry of the Interior. (2025). *The Federal Minister of the Interior*. Retrieved from https://www.bmi.bund.de/EN/ministry/minister/minister-node.html

Korean National Police Agency. (2025). *Organization of the Korean National Police Agency – National Office of Investigation*. Retrieved from Korean National Police Agency: https://www.police.go.kr/eng/knpa/org/org01.jsp

Supreme Prosecutors' Office of Korea. (2025). *Anti-Corruption Department (Planning & Coordination Division, Division 1, Division 2)*. Retrieved from Supreme Prosecutors' Office of Korea: Supreme Prosecutors' Office of Korea

Supreme Prosecutors' Office of Korea. (2025). *Anti-Corruption Department (Division 1, 2, 3)*. Retrieved from Supreme Prosecutors' Office of Korea: https://www.spo.go.kr/site/eng/01/1010200000000020181206O5.jsp?utm

United Nations. (2003). *United Nations Convention against Corruption.* Retrieved from United Nations: https://www.unodc.org/unodc/en/corruption/convention.html

Ebrary.net. (n.d.). *Abuse of functions: Article 19.* Retrieved from https://ebrary.net/57580/law/abuse_functions_article

Australian Federal Police. (2025). *Fraud and corruption*. Retrieved from https://www.afp.gov.au/crimes/fraud-and-corruption

Parliament of Australia. (n.d.). *Role of the Committee (Parliamentary Joint Committee on the National Anti-Corruption Commission).* Retrieved from https://www.aph.gov.au/parliamentary_business/committees/joint/national_anti-corruption_commission/role_of_the_committee

Prosecutor General's Office. ((n.d.)). *The supreme supervision of compliance with the rule of law on the territory of the Republic of Kazakhstan on behalf of the state.* Retrieved from https://www.gov.kz/memleket/entities/prokuror/activities/1523?lang=en

Library of Congress (U.S.). (2023, June). *South Korea: Public Prosecution Reform (overview of 2020–2022 reforms limiting prosecutors' command over police and introducing re-investigation requests)*. Retrieved from Library of Congress: https://tile.loc.gov/storage-services/service/ll/llglrd/2023555904/2023555904.pdf

Germany. Federal Ministry of Justice. (2024). *Strafprozessordnung (German Code of Criminal Procedure — StPO) (esp. §160-163, § 170; English interface)*. Retrieved from Gesetze im Internet: https://www.gesetze-im-internet.de/englisch_stpo/?utm

ХАВСРАЛТУУД

Хавсралт 1. Австрали Холбооны Улсын 1995 оны Эрүүгийн хуулиас[33]

(Албан бус орчуулга)

7 дугаар бүлэг - ТӨРИЙН ЗӨВ ЗОХИСТОЙ УДИРДЛАГА

7.6 дугаар хэсэг - АВЛИГЫН БОЛОН ХОЛБОГДОХ ГЭМТ ХЭРЭГ

142.2 дугаар зүйл. Нийтийн албан тушаалаа урвуулан ашиглах

(1) Холбооны нийтийн албан тушаалтан дараах нөхцөлд гэмт хэрэг үйлдсэнд тооцно:

(a) тухайн албан тушаалтан:

(i) Холбооны нийтийн албан тушаалтны хувьд өөрт олгогдсон нөлөөгөө ашигласан;, эсхүл

(ii) Холбооны нийтийн албан тушаалтны албан үүргээ гүйцэтгэх явцад аливаа үйлдэлд хийсэн; эсхүл

(iii) Холбооны нийтийн албан тушаалтны хувьд олж авсан аливаа мэдээллийг ашигласан; бөгөөд

(b) дээрх үйлдлийг дараах зорилгоор хийсэн бол:

(i) өөртөө буюу бусдад хууль бус ашиг хүртэх; эсхүл

(ii) бусдад хууль бус хохирол учруулах.

Ял шийтгэл: тав хүртэл жилийн хорих ял.

(2) Тухайн этгээд дараах нөхцөлд энэ зүйлд заасан гэмт хэргийг үйлдсэнд тооцно:

(a) тухайн этгээд өмнө нь холбооны нийтийн албан тушаалтан байсан боловч тухайн албан тушаалаас чөлөөлөгдсөн; бөгөөд

(b) албан тушаал эрхэлж байх хугацаандаа олж авсан мэдээллийг ашигласан; бөгөөд

(c) тухайн этгээд дээрх үйлдлийг дараах зорилгоор хийсэн бол:

(i) өөртөө буюу бусдад хууль бус ашиг хүртэх;, эсхүл

(ii) бусдад хууль бусаар хохирол учруулах.

Ял шийтгэл: тав хүртэл жилийн хорих ял.

(3) (2)(a)-д заасан “албан тушаалаас чөлөөлөгдөх” заалт нь дараах нөхцөлд хамаарна:

(a) тухайн этгээд Холбооны нийтийн албан тушаалтан хэвээр үлдсэн эсэхээс үл хамааран; болон

(b) тухайн албан тушаалаас чөлөөлөгдсөн хугацаа нь энэ заалт хүчин төгөлдөр болохоос өмнө, эсхүл хүчин төгөлдөр болох үед, эсхүл түүнээс хойш гарсан эсэхээс үл хамааран хүчин төгөлдөр үйлчилнэ.

[33] Австрали: Criminal Code Act (1995). Хандах: https://www.legislation.gov.au/C2004A04868/2018-12-29/text

Хавсралт 2. Бүгд Найрамдах Казахстан Улсын Эрүүгийн хуулиас[34]

(Албан бус орчуулга)

Бүлэг 15. ТӨРИЙН АЛБА БОЛОН ТӨРИЙН УДИРДЛАГЫН АШИГ СОНИРХЛЫН ЭСРЭГ ҮЙЛДЭГДСЭН АВЛИГЫН БОЛОН БУСАД ГЭМТ ХЭРЭГ

361 дүгээр зүйл.Албан тушаалаа урвуулан ашиглах

1.Төрийн үүрэг гүйцэтгэх эрх бүхий этгээд, түүнтэй адилтгах этгээд, эсхүл албан тушаалтан өөрийн албан тушаалын бүрэн эрхийг төрийн албаны ашиг сонирхолд харш байдлаар, өөрийн болон бусдын, эсхүл хуулийн этгээдийн ашиг, давуу байдлыг бий болгох, эсхүл бусад этгээд, байгууллагад хохирол учруулах зорилгоор урвуулан ашиглаж,

ингэхдээ иргэн, байгууллагын хууль ёсны эрх, ашиг сонирхолд, эсхүл нийгэм, төрийн хамгаалагдсан ашиг сонирхолд үлэмж хохирол учруулсан бол дараах шийтгэл ногдуулна: хоёр мянга хүртэл сарын тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний торгууль, эсхүл зургаан зуун цаг хүртэл хугацаагаар олон нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар эрх чөлөөг хязгаарлах, эсхүл ижил хугацаагаар хорих ял оногдуулна,

мөн эд хөрөнгийг хураах, тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг насан туршид нь хасна.

2.(2018 оны 7 дугаар сарын 12-ны өдрийн № 180-VI хуулиар хүчингүй болсон).

2-1.Дээр дурдсан үйлдлийг хууль сахиулах байгууллагын ажилтан үйлдсэн бол

дөрвөн мянга хүртэл сарын тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний торгууль, эсхүл ижил хэмжээгээр засч залруулах ажил, эсхүл нэг мянган цаг хүртэл хугацаагаар олон нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл дөрвөн жил хүртэл хугацаагаар эрх чөлөөг хязгаарлах, эсхүл ижил хугацаагаар хорих ял оногдуулна, мөн эд хөрөнгийг хураах, тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг насан туршид нь хасна.

3.Энэ зүйлийн нэг дэх хэсэгт заасан үйлдлийг төрийн хариуцлагатай албан тушаал эрхэлж буй этгээд үйлдсэн бол таван мянга хүртэл сарын тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний торгууль, эсхүл ижил хэмжээгээр засч залруулах ажил, эсхүл нэг мянга хоёр зуун цаг хүртэл хугацаагаар олон нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл тав хүртэл жилийн хугацаагаар эрх чөлөөг хязгаарлах, эсхүл ижил хугацаагаар хорих ял оногдуулна, мөн эд хөрөнгийг хураах, тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг насан туршид нь хасна.

4.Энэ зүйлийн 1, 2-1 болон гурав дахь хэсэгт заасан үйлдэл дараах нөхцөлд үйлдэгдсэн бол:

1) гэмт хэргийн бүлгийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн;

2) “Казахстан Улсын иргэд, оралмануд, оршин суух зөвшөөрөл бүхий этгээдийн өмчийг хууль ёсны болгохтой холбогдуулан өршөөл үзүүлэх тухай” хуулийн дагуу өмчийг хууль ёсны болгох ажиллагаанд оролцох явцад олж авсан мэдээллийг ашигласан;

3) хүнд хор уршиг учруулсан;

[34] Казахстан: Уголовный кодекс (2014). Хандах: https://online.zakon.kz/Document/?doc_id=31575252&pos=5;-109#pos=5;-109

4) хууль сахиулах байгууллагын хариуцлагатай албан тушаалтан, эсхүл шүүгч ийм үйлдэл хийсэн бол долоо хүртэл жилийн хугацаагаар эрх чөлөөг хязгаарлах, эсхүл ижил хугацаагаар хорих ял оногдуулна, мөн эд хөрөнгийг хураах, тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг насан туршид нь хасна.

Хавсралт 3. Бүгд Найрамдах Солонгос Улсын Эрүүгийн хуулиас[35]

(Албан бус орчуулга)

Бүлэг VII. НИЙТИЙН АЛБАН ТУШААЛТНЫ ҮҮРЭГТЭЙ ХОЛБООТОЙ ГЭМТ ХЭРЭГ

123 дугаар зүйл. Эрх мэдлээ урвуулан ашиглах

Нийтийн албан хаагч нь өөрийн албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглаж, бусдад хуульд заагаагүй үүрэг биелүүлэхийг албадсан; эсхүл тухайн этгээд хууль ёсны эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулсан бол тав хүртэл жилийн хугацаагаар хорих, эсхүл арван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал эрхлэх эрхийг хасах, эсхүл арван сая воноос хэтрэхгүй хэмжээний торгох ял оногдуулна.

Хавсралт 4. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Эрүүгийн хуулиас[36]

(Албан бус орчуулга)

Бүлэг 30. АЛБАН ТУШААЛТАЙ ХОЛБООТОЙ ГЭМТ ХЭРЭГ

339 дүгээр зүйл. Шүүхийн шударга ёсыг гажуудуулах

Шүүгч, албан тушаалтан, эсхүл арбитр нь хэргийг шийдвэрлэхдээ хууль тогтоомжийг аль нэг талын ашиг, эсхүл хохирол учруулах зорилгоор зориудаар гажуудуулсан бол нэгээс таван жил хүртэлх хугацаагаар хорих ял оногдуулна.

344 дүгээр зүйл. Гэм буруугүй этгээдийг яллах

(1) Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд (11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалтад хамаарах эрх чөлөөг хязгаарлаагүй арга хэмжээг оногдуулах ажиллагаанаас бусад тохиолдолд) оролцож буй албан тушаалтан гэм буруугүй этгээд, эсхүл хуульд зааснаар эрүүгийн хариуцлагад татах боломжгүй этгээдийг зориуд, эсхүл мэдсээр байж ялласан, эсхүл ийм ял оногдуулахыг санаатайгаар оролдсон бол нэгээс арав хүртэл жилээр хорих ял оногдуулна. Харьцангуй хөнгөн тохиолдолд гурван сараас таван жил хүртэл хорих ял ногдуулна. Эхний өгүүлбэрийн зохицуулалтыг албан тушаалтан албан ёсны шийдвэрээр хорих арга хэмжээ авах ажиллагаанд оролцсон тохиолдолд адил хэрэглэнэ.

(2) Эрх чөлөөг хязгаарладаггүй арга хэмжээг оногдуулах ажиллагаанд (11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалт) оролцож буй албан тушаалтан хуулиар яллах боломжгүй этгээдийг зориуд, эсхүл мэдсээр байж ялласан, эсхүл ийм ялыг оногдуулахыг санаатайгаар оролдсон бол гурван сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял

[35] Солонгос: Criminal Act (2013). Хандах: https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=28627&lang=ENG
[36] Казахстан: Уголовный кодекс (2014). Хандах: https://online.zakon.kz/Document/?doc_id=31575252&pos=5;-109#pos=5;-109

оногдуулна. Эхний өгүүлбэрийн зохицуулалтыг мөн дараах ажиллагаанд оролцож буй албан тушаалтанд адил хэрэглэнэ:

1.зохион байгуулалтын (зөрчлийн) торгуулийн ажиллагаа;

2.сахилгын ажиллагаа, сахилгын шүүх, эсхүл мэргэжлийн сахилгын шүүхийн ажиллагаа.

Ийм үйлдэл хийхийг оролдсон бол ял шийтгэнэ.

345 дүгээр зүйл. Гэм буруугүй этгээдэд шийтгэх шийдвэрийг хууль бусаар гүйцэтгэх

(1) Эрх бүхий албан тушаалтан нь хорих ял, эрх чөлөөг хязгаарлах шинжтэй хүмүүжлийн болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ, эсхүл албан тушаалтны тушаалаар саатуулах шийдвэрийг хэрэгжүүлэхдээ, хуульд зааснаар гүйцэтгэх боломжгүй шийтгэл, саатуулах ажиллагааг санаатайгаар гүйцэтгэсэн бол нэг жилээс арван жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулна.

Хэрэв энэ үйлдэл нь хөнгөн шинжтэй бол гурван сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулна.

(2) Хэрэв тухайн албан тушаалтан болгоомжгүйгээр ийм үйлдэл хийсэн бол нэг жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл мөнгөн торгууль оногдуулна.

(3) Эрх бүхий албан тушаалтан нь (1)-д заасан хорих ял, эрх чөлөөг хязгаарлах арга хэмжээнээс бусад төрлийн шийтгэл, арга хэмжээг гүйцэтгэхдээ, тухайн шийтгэл, арга хэмжээг хууль ёсоор гүйцэтгэх боломжгүй гэдгийг мэдсээр байж дараах шийтгэлийг хууль бусаар хэрэгжүүлсэн бол эрүүгийн хариуцлага хүлээнэ. Ийм үйлдэлд гурван сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулна. Үүнд:

1.насанд хүрээгүй хүнийг хорих;

2.зөрчлийн хуулиар ногдуулсан торгууль, эсхүл нэмэлт эрх зүйн үр дагавар;

3.шүүхийн шийдвэр биелүүлэхээс татгалзсан этгээдэд албадлагын торгууль, эсхүл баривчлах шийдвэрийг хууль бусаар хэрэгжүүлсэн. Ийм үйлдэл хийхийг оролдсон бол ял шийтгэнэ.

348 дугаар зүйл. Албан бичиг баримтыг хуурамчаар үйлдэх

(1) Нийтийн баримт бичгийг бүртгэх эрх бүхий албан тушаалтан өөрийн харьяаллын хүрээнд хууль зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг худал бичиж баталгаажуулсан, эсхүл түүнийг нийтийн бүртгэл, ном буюу өгөгдлийн санд худал бүртгэн оруулсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл торгох ял оногдуулна.

(2) Ийм үйлдэл хийхийг оролдсон бол ял шийтгэнэ.

352 дугаар зүйл. Илүү төлбөр, хөлс нэхэмжлэх

(1) Албан тушаалтан, өмгөөлөгч, эсхүл хууль зүйн туслалцаа үзүүлдэг этгээд нь албан үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан хууль ёсоор авах ёстой хэмжээнээс илүү төлбөр, хөлсийг санаатайгаар нэхсэн, эсхүл өөрт ногдох ёсгүй төлбөр, хөлсийг авсан бол нэг жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл торгох ял оногдуулна.

(2) Ийм үйлдэл хийхийг оролдсон бол ял шийтгэнэ.

353 дугаар зүйл. Илүү татвар, төлбөр хураах, хууль бусаар хөнгөлөлт бууруулах

(1) Татвар, төлбөр болон бусад төрлийн орлогын хураамжийг улсын санд төвлөрүүлэх үүрэг бүхий албан тушаалтан нь хууль ёсоор ногдох ёстой хэмжээнээс илүү төлбөр, хураамж хураан авч, хууль бусаар хураасан орлогыг бүрэн буюу хэсэгчлэн улсын санд тушаагаагүй бол гурван сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулна.

(2) Албан тушаалтан нь мөнгө, эд зүйл хуваарилах, олгох ажиллагааны үед хууль бусаар төлбөрийн тодорхой хэсгийг хасаж, бүрэн олгосон мэтээр бүртгэлд тусгасан бол мөн адил гурван сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулна.

358 дугаар зүйл. Нэмэлт эрх зүйн үр дагавар

Энэ хуулийн 332, 335, 339, 340, 343, 344 дүгээр зүйл, 345 дугаар зүйлийн (1) ба (3) дахь хэсэг, 348, 352-353b дүгээр зүйлийн (1) дэх хэсэг, мөн 355 ба 357 дугаар зүйлд заасан гэмт хэргийг үйлдэж зургаан сараас дээш хугацаагаар хорих ял авсан тохиолдолд шүүх тухайн этгээдийг нийтийн албан тушаал эрхлэх эрхийг хасаж болно (45 дугаар зүйлийн (2) дахь хэсэг).